



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

№04
2024 ОН

2024.05.01

СЭТГҮМ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ:

“ ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ
ШИНЭ ШАТАНД ГАРГАНА



WWW.HUNSNIIHUVISGAL.MN

Сангийн сайд Б.ЖАВХЛАН:

“ ЭДИЙН ЗАСГИЙГ
ТӨРӨЛЖҮҮЛЭХ ХАМГИЙН
БОЛОМЖТОЙ САЛБАР БОЛ
ХӨДӨӨ АЖ АХУЙ ЮМ

ҮНДЭСНИЙ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ТУЛГЫН ЧУЛУУ БОЛСОН
ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭР

МОНГОЛ УЛС
ХҮНСНИЙ
ХАНГАМЖААР
“ТУСГААР ТОГТНОХ”
ШАЛТГААН

“ЦАГААН
АЛТ”
ҮНДЭСНИЙ
ХӨДӨЛГӨӨН

УИХ-ын “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 онд санхүүжих дүн /мян.төг/

215,210,335.50

Үржлийн хээлтүүлэгч болон цөм сүргийн хээлтэгч малыг ялган төвлөрүүлэх замаар мэргэжилтний хяналтад авах

500,000.00



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, соён гэгээрүүлэх

100,000.00

Иргэн, хувийн хэвшил, төрийн бус, байгууллагын зохион байгуулж байгаа хоол, хүнсний зохистой хэрэглээний талаарх соён гэгээрүүлэх боловсролыг дэмжих ажилд дэмжлэг үзүүлэх

50,000.00

Малын таримал тэжээлийн тариалалт, үйлдэрлэлийг нэмэгдүүлэхэд үрийн нөөц бүрдүүлэх

1,962,000.00

Малд үзлэг, ангилалт хийж ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, удам зүйн үнэлгээ хийх замаар малын ашиг шимийн үзүүлэлтийг тодорхойлох, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх

500,000.00

Бэлчээрийн ашиглалт, хамгааллыг сайжруулах, отрын нөөц бэлчээр, усан хангамж, өвс, тэжээлийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх

2,000,000.00

Малын удмын санг хамгаалах, мал үржүүлэг, технологийн ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн нэгжийн үйл ажиллагааг дэмжих

500,000.00

Зөгийн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүсчлэл, хамтын ажиллагааны цар хүрээгээр кластерын зохион байгуулалтад оруулж, бодлогоор дэмжиж, мэргэжлийн холбоодын үйл ажиллагаанд түшиглэн хөгжүүлэх

500,000.00

Хүнсний болон үрийн улаан буудайн нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, эргэлтийн хөрөнгийн сантай болох

30,000,000.00

Тариалангийн үйлдвэрлэлийг эрсдлээс хамгаалах, бүс нутагт тохирсон таримал, сорт сонгох зорилгоор анхан шатны үр үржүүлэг, сорт сорилтын төвийг байгуулах

440,000.00

Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн механикжуулалтыг сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийж зорилгоор тухайн жилд худалдан авсан техникт 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх

3,924,000.00

Бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох

4,414,500.00

Тариалангийн газрын төлөв байдал, хөрсний үржил шим, элэгдэл, эвдрэлийн үзүүлэлтүүдийг шинэчлэх

300,000.00

Таримлын шинэ сорт бүтээх, нутагшуулах, турших, тэдгээрийн сортын элит баталгаат үр үржүүлэхийг дэмжих, шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх

100,000.00

Таримал ургамлын сортын бүртгэл хөтлөх, таримал тус бүрээр үр, үрслэг, суулгац үйлдвэрлэгч, борлуулагчдыг бүртгэх, цахим мэдээллийн санг бий болгох

50,000.00

Жимс, жимсгэнийн төрөлжсөн аж ахуй байгуулах, санхүүжилт, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх, тариалах технологи боловсруулах

3,340,000.00

Орон нутагт жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв байгуулах

1,000,000.00

Нийт мэдрэмтгий мал, амьтныг жилд 2 удаа дархлаажуулалтад хамруулах

41,733,000.00

Хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлт, тээвэрлэлт, борлуулалтын нэгдсэн сүлжээг бий болгох, Загвар хоршоодыг байгуулах

1,000,000.00

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын шилдэг 100 үйлдвэрлэгчийг шалгаруулан урамшуулах

100,000.00

Хөрөнгө оруулалтын болон эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт

122,696,835.50

Монгол Улс хүнсний хангамжаар
“тусгаар тогтнох” шалтгаан

13



Шинээр байгуулах
аж үйлдвэрийн паркууд

17



23

ХАА-н салбарт гадаад зээл,
тусламжаар хэрэгжих
ОНЦЛОХ ТӨСЛҮҮД



53

Үндэсний
үйлдвэрлэлийн
тулгын чулуу болсон
**ХӨНГӨН АЖ
ҮЙЛДВЭР**

“Цагаан алт”

үндэсний хөдөлгөөн




64

Хүнсний хувьсгал, Цагаан
алт, Шинэ хоршоо үндэсний
хөдөлгөөнүүд нь цогцоороо
хэрэгжиж, Хөдөө аж
ахуйн салбарт томоохон
ХУВЬСГАЛ хийнэ.

Үндэсний үйлдвэрлэгчдэд
төрийн дэмжлэг
хамгийн чухал

70





МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ:



ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ШИНЭ ШАТАНД ГАРГАНА

Хөнгөн аж үйлдвэрийн салбарын 90 жилийн ойн улсын зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн хэлсэн үг

Эрхэм хүндэт үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид ээ,

Эх орныхоо хөгжил дэвшил, ард түмнийхээ аж амьдралын сайн сайхны төлөө оюун ухаан, хөдөлмөр зүтгэлээ зориулан ажиллаж буй хөнгөн үйлдвэрийн салбарын ажилтан, албан хаагчид болон үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчид Та бүхэндээ Монгол улсад орчин цагийн хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний түүхт 90 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Аливаа улс орны хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдал, ард түмний аж амьдралд аж үйлдвэрийн салбарын хөгжил дэвшил чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тэртээ 1934 онд дэвшилтэт техник, технологи бүхий аж үйлдвэрийн салбарын суурь тавигдаж, “Аж үйлдвэрийн комбинат” үйл ажиллагаагаа эхлүүлсэн нь манай улсын орчин цагийн хөнгөн аж үйлдвэрийн салбарын хөгжлийн эхлэл байсан түүхтэй.

1930-аад оноос өмнө энэ салбар нь гар урчууд, төмөр болон мөнгөний дархчуудаас бүрдсэн “Гар үйлдвэрлэл” дээр голлон түшиглэж байлаа.

Харин 1940-1950 онуудад малын гаралтай түүхий эдээ ашиглан дотоодын хэрэгцээг хангах, гадаад зах зээлд бараа, бүтээгдэхүүнээ гаргах чиглэлд тодорхой ахиц дэвшил гарсан юм.

Цаашлаад 1960-1990 онуудад манай улсад олон хөнгөн аж үйлдвэрүүд шинээр бий болж, түүхий эдийн боловсруулалтын түвшин, үр ашиг, чанарын үзүүлэлтүүд эрс сайжирч, шаардлагатай боловсон хүчнийг ч эх орондоо бэлдэж байсан түүхтэй.



Харин 1990 оноос манай улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих нийгмийн цогц өөрчлөлт, шинэчлэлтийг өрнүүлж эхэлсэн.

Энэхүү шилжилтийн цаг үе ч аж үйлдвэрийн салбарыг тойроогүй юм.

Олон аж үйлдвэрүүд, үйлдвэр комбинатуудын хэвийн үйл ажиллагаа доголдож, олон мянган монголчууд ажлын байраа алдсан гашуун түүх бидэнд сургаж болон үлдсэн.

Энэхүү нийгэм, эдийн засгийн шилжилтийн хүндхэн цаг үе 10 орчим жил үргэлжилж, 2000 оноос эхлэн зах зээлийн нийгэмд тохирсон аж үйлдвэрийн шинэ бодлого, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр хэрэгжсэний үр дүнд ноос, ноолуур, арьс шир, оёдол, тавилга, монгол гэр, модон эдлэл, хэвлэл зэрэг цөөнгүй салбарууд сэргэж эхэлсэн.

Мөн сав баглаа боодол, хог хаягдал боловсруулах, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг цөөнгүй хөнгөн үйлдвэрүүд шинээр үүсэн хөгжиж, уг салбарын үйлдвэрлэл, экспорт, ажлын байр шилжилтийн цаг үеэс харьцангуй сэргэсэн бөгөөд ийнхүү алдаа оноо, амжилт бүтээл, сургаж туршлага хосолсон түүхийн 90 жилийг монголчууд бид хамтдаа туулж байна.

Эрхэм хүндэт нөхөд өө,

Эзэн богд Чингис хаан нэгэнтээ “Чи бусдын хийсэн хоолыг идэж, бусдын хийсэн хувцсыг өмссөн тэр цагт бусдын боол болсон хэмээн бодоорой” гэж айлдсан гэдэг.

Бидний өвөг дээдэс өнө эртнээс нүүдлийн мал аж ахуй эрхэлж хоол хүнс, дээл хувцас, эд зүйлсээ өөрсдөө үйлдвэрлэж, худалдаа наймаа эрхэлж, бусдаас хараат бус оршин тогтнож ирсэн түүхтэй.

Өмнөх нийгмийн он жилүүдэд ч хүнд, хөнгөн аж үйлдвэрийн хөгжил эрчимжиж хүнс болон



Үр дүнд нь хөнгөн үйлдвэрийн салбар манай улсын нийт аж үйлдвэрийн салбарын 60 гаруй хувийг дангаараа бүрдүүлж, нийт 41 мянган хүн энэ салбарт ажиллаж, манай улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болон хөгжиж байлаа.





бусад аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ гадаад зах зээлд экспортолж байсан билээ.

Өвөг дээдсийн сургаал, түүхэн туршлагаас харахад монголчууд бид аж үйлдвэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж, экспорт хийж, үндэсний аюулгүй байдлаа баталгаажуулж ирснийг илтгэж байна.

Аж үйлдвэрийн салбар тэр дундаа хөнгөн үйлдвэрийн салбар 2000 оноос сэргэж байгаа хэдий ч импортоос өндөр хамааралтай, эмзэг хэвээр байна.

1980-аад оны сүүл гэхэд хөнгөн үйлдвэрийн салбар нийт аж үйлдвэрийн салбарын 60 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байсан бол 2023 оны байдлаар дөнгөж 25 хувийг л бүрдүүлж байна.

Хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын дөнгөж 6 хувьтай тэнцэж байна.

Харин нөгөө талдаа хүнс, гутал, хувцас, арьс, савхин эдлэлээс эхлээд хөнгөн үйлдвэрийн шинжтэй бараа бүтээгдэхүүн гадаадаас худалдан авахад жилд ойролцоогоор 3 тэрбум орчим ам.долларыг монголчууд бид гадагшаа урсгаж байна.

Энэ бол чаддаг байсан зүйлээ чадахгүй болсны тод илрэл юм.

Үүнд л бид анхаарлаа хандуулж, алдаагаа засах учиртай.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд тохиолдсон цар тахал, дайн тулаан, тээвэр логистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, өлсгөлөн, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэрэг нь улс орон бүрийг аж үйлдвэрийн салбартаа онцгой анхаарахыг сануулсаар байна.

Тийм ч учраас хүн ардынхаа хүнсний аюулгүй



байдал, хүнсний хангамжийг сайжруулах, дагалдах хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгч “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг улс орон даяар өрнүүлж байгаа билээ.

Энэ ажлын хүрээнд хүнсний үйлдвэрүүд болон сав баглаа боодол зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ажиллаж буй иргэд, аж ахуй нэгжүүдэд чиглэсэн гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бага хүүтэй, урт хугацаатай санжүүжилт олгох зэрэг олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд нийт 1 их наяд гаруй төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.

Үүний үр дүнд баялаг бүтээгчид, үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжин тэлж, зохих амжилтад хүрч, бодит үр дүн гарч эхлээд байгааг энэхүү баярын өдөр тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Тухайлбал, хүнсний салбарт 2023 онд олон улсын шаардлагад нийцсэн мал төхөөрөх 2, мах боловсруулах 2, бяслаг үйлдвэрлэх 7 буюу нийт 11 үйлдвэр шинээр ашиглалтад орлоо.

Мөн 2023 онд жимс жимсгэнэ, хүнсний ногооны нэр төрөл нэмэгдэж, түүхэндээ анх удаа хамгийн өндөр хэмжээний ургац хураан авч, хүнсний ногооны дотоодын хангамж 85 хувьд хүрлээ.

Түүнчлэн сонгино, саримс, лууван болон өндөгний дотоодын хангамж 2023 онд 3-12 хувиар өсөж, махны экспорт эрс нэмэгдэж, 185 орчим сая ам.долларын экспортын орлого оллоо.

Манай улсын хүнсний бүтээгдэхүүний импорт 10 хувиар буурч, 1 тэрбум гаруй ам.доллароор гадаадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан бол энэ жил 110 орчим сая ам.долларыг эх орондоо үлдээж чадлаа.

Дээр дурдсан олон эерэг, нааштай үзүүлэлтүүд нь төр, хувийн хэвшлийн бодлого, зорилт нэг байж, харилцан ойлголцож, хамтран ажиллаж чадвал тодорхой үр дүнд хүрч болохын бодит жишээ гэж үзэж байна.



Монголчууд бид хонины ноос хэмээх “цагаан алт”-аа үр ашигтайгаар бүрэн дүүрэн ашиглах ёстой



Харин одоо Та бид хамтдаа хөнгөн үйлдвэрийн бусад салбартаа онцгой анхаарах ёстой.

Ялангуяа, олон зуун жилийн нүүдлийн мал аж ахуйн соёлтой, 70 гаруй сая малтай манай улс малын гаралтай түүхий эдээ бүрэн боловруулж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ганцхан жишээ хэлэхэд Монгол улс жилдээ 38 мянган тонн хонины ноос бэлтгэж байгаа ч үүний 75 хувийг нь нэмүү өртөг шингээлгүй зөвхөн угаагаад экспортолж байна.

Судалгаанаас харахад хэрэв хонины ноосоо дотооддоо бүрэн боловруулж чадвал энэ салбарын орлого 5-6 дахин нэмэгдэх боломжтой юм.

Өөрөөр хэлбэл, монголчууд бид хонины ноос хэмээх “цагаан алт”-аа үр ашигтайгаар бүрэн дүүрэн ашиглах ёстой.

Мөн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөө эрчимжиж, ган зудын давтамж жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь бэлчээрийн мал аж ахуйд суурилсан манай улсын хүнс, хөдөө аж ахуйн салбар цаашид тогтвортой хөгжих, орон нутгийн

иргэд, малчдын орлого дорвитой сайжрахад томоохон эрсдэл, хязгаарлалт болж байна.

Ялангуяа өнгөрсөн жилийн үер усны гамшиг, энэ өвлийн зуд турханы байдал монголчууд бидний ажил, амьдралд томоохон сануулга боллоо.

Цаашид бид хөнгөн үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах, тэр дундаа өсөн үрждэг баялаг болох мал, малын гаралтай түүхий эдийг үнэ цэнэтэй болгох, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлд бодит үр дүнд хүрэх шаардлагатай байна. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг санаачлан, улс орон даяар өрнүүлэхээр төлөвлөж байна.





Бусад орны сайн туршлагаас үзэхэд хөнгөн үйлдвэрийн салбарыг хурдтай хөгжүүлэхэд чөлөөт өрсөлдөөн, худалдаа, татвар, санхүү, хөдөлмөрийн зах зээл, технологи, гадаадын хөрөнгө оруулалт, хүний нөөц бэлтгэх зэрэг цогц, нэгдмэл, харилцан бие биеэ дэмжсэн бодлого хэрэгжүүлэх нь чухал байдаг.

Судалгаанаас харахад манай орны хөнгөн үйлдвэрийн салбарт арьс, арьсан бүтээгдэхүүн, тэдгээрийн тоног төхөөрөмж, үйлдвэрийн машины эд ангиуд, цаас, цаасан бүтээгдэхүүн болон хувцас, нэхмэлийн үйлдвэрүүдийг хөгжүүлснээр экспортыг нэмэгдүүлэх, олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэсэн байна.

Дэлхийн Банкны судалгаагаар манай улсад гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой тэргүүлэх салбаруудаар ноолуурын үйлдвэрлэл, мах боловсруулах үйлдвэрлэл, эрчимжсэн фермерийн аж ахуй түүн дотроо сүү, сүүн бүтээгдэхүүн, сүүний чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйг нэрлэсэн байдаг.

Түүнчлэн малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанар хангалтгүй, малын өвчин, малын гарал үүсэл тодорхойгүй, вакцинжуулалт хангалтгүй байгаа зэрэг нь хөнгөн үйлдвэрийн салбарт ихээхэн чөдөр тушаа болж ирсэнийг ч судлаачид сануулсаар байна.



Тиймээс цаашид бид хөнгөн аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэхэд дараах асуудлуудыг онцгой анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- **Хөнгөн аж үйлдвэрийн салбарын эрх зүй, санхүү, татвар, даатгалын таатай орчныг бий болгох;**
- **Байгаль орчин, мал амьтанд ээлтэй, өндөр чанартай түүхий эд бэлтгэх болон малын гарал үүсэл, чанарын мөшгөх тогтолцоог хөгжүүлэх;**
- **Үйлдвэрлэлийн хүчин чадал, ашиглалтыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;**
- **Хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, давтан сургах;**
- **Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зэрэг үйл ажиллагаанд онцгой анхаарах шаардлагатай байна.**

Дээрх зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн оновчтой түншлэл, харилцаа, хамтын ажиллагаа, харилцан ойлголцол, нэг зорилго, нэг бодлого хамгийн чухал гэдгийг онцлон тэмдэглэж байна.



Эрхэм нөхөд өө,

Олон мянган жил хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн монголчууд бид хөнгөн үйлдвэрийн салбараа дэлхийн жишигт хүргэн, шинжлэх ухаанч байдлаар хөгжүүлж, **ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ** орон болоход манай баялаг бүтээгч, үйлдвэрлэгчид Та бүхэн онцгой чухал үүрэгтэй.

Та бүхний хичээл зүтгэлээс улс орны хөгжил дэвшил, хүн ардын сайн сайхан амьдрал шууд шалтгаална. Та бүхэн бол манай улсын хөгжил дэвшлийн ундарга, хөдөлгөгч хүч юм.

Хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлснээр ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, өрх бүлийн амьжиргааг дээшлүүлэх, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зэрэг улс орны хөгжил дэвшилтэй холбоотой нийгэм, эдийн засгийн олон төрлийн үр өгөөж, ашиг орлогыг авчирдаг.

Энэ их үйлсийн төлөө хүчин зүтгэж буй хөнгөн үйлдвэрийн салбарын хамт олон Та бүхнийг Монгол Улсын Ерөнхийлөгч бүх талаар тууштай дэмжиж, хамтран ажиллах болно.

Өрх бүлээрээ үйлдвэрлэгч, улс орноороо экспортлогч болохын төлөө төр засаг, түмэн олноороо нэгдэн нийлж, нэгэн сэтгэлээр хамтран зүтгэцгээе.

Эрхэм хүндэт үйлдвэрлэгч, баялаг бүтээгч Та бүхэндээ Монгол Улсад орчин цагийн хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсэж хөгжсөний түүхт 90 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол Улс мандан бадрах болтугай!

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**





Сангийн сайд
Б.Жавхлан:

“ Эдийн засгийг төрөлжүүлэх хамгийн боломжтой салбар бол хөдөө аж ахуй юм

*Монгол Улсын Ерөнхийлөгч
У.Хүрэлсүхийн санаачилсан
“Хүнсний хувьсгал” үндэсний
хөдөлгөөн, түүний ач холбогдол,
эдийн засгийн нөлөөлөл,
Сангийн яамнаас хэрэгжүүлж
байгаа бодлого, арга хэмжээний
талаар Сангийн Сайд
Б.Жавхлантай ярилцлаа.*

Монгол Улс хүнсний хэрэглээгээ дотоодоосоо 100 хувь хангах зорилт бүхий “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг эхлүүлээд хоёр дахь жилдээ орж байна. Үндэсний хэмжээний энэ том хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдал үүссэн гэж ойлгож байгаа?

- Дэлхий нийтийг хамарсан Цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй хилийн хязгаарлалт, тээвэр логистикийн хүндрэлүүд үүсээнийг та бид мэдэж байгаа. Олон улсын нийлүүлэлтүүд доголдож эхэлсэн нь сүүлийн жилүүдэд маш тулгамдсан асуудал болсон. Ялангуяа манай улс шиг хүнсний хэрэглээнийхээ 50-иас илүү хувийг импортоор

авдаг орны хувьд бодит хомсдол үүсэж, хүнсний бүтээгдэхүүний үнийн хэт өсөлтийг бий болгож байна. Инфляц өсөхөд эдгээр асуудал шууд нөлөөлсөн. Нөгөө талаас уул уухайн салбараас шууд хамааралтай манай улсын хувьд эдийн засгаа төрөлжүүлэх зайлшгүй шаардлага гарч ирлээ. Үүнд хөдөө аж ахуй бол хамгийн боломжтой хөгжих салбар юм. Тийм учраас хөдөө аж ахуйн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд хүнсний болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг дотоодоосоо хангадаг байх нь маш том хөшүүрэг болно. Хамгийн гол нь эрүүл, аюулгүй хүнсээр иргэдээ хангаж, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэлийг Олон улсын стандартад



нийцүүлэн хөгжүүлснээр хүнс экспортлогч орон болох зам нээгдэнэ. Энэ нь Монгол Улсын эдийн засагт бодит өсөлтийг авчрах юм.

Хүнсний хэрэглээнийхээ 50-иас илүү хувийг импортоор хангадаг гэж байна. Тэгэхээр мөнгөн дүнгээр бол жилдээ хэд орчим валютыг хүнсний импортод гадагш урсгаж байгаа бол?

- Баахан л тоон баримт хэлэх болох нь. Хөдөө аж ахуйн салбар бол манай улсын ДНБ-ний 15 орчим хувийг бүрдүүлдэг. Нийт ажиллах хүчний 50-60 хувь нь энэ салбарт ажиллаж байна. Гэсэн хэдий ч бид жилд дунджаар 2.7 их наяд төгрөгийг хүнс импортлоход зарцуулдаг. Бүр нарийвчлан хэлбэл, 2021 онд 0.96 тэрбум ам.доллар, 2022 онд 1.1 тэрбум ам.доллар, 2023 онд 1.0 тэрбум ам.долларыг хүнсний импортод зарцуулсан байна. Энэ нь нийт импортын 11-13 хувийг эзэлж байгаа.

Бид хүнсээ үнэхээр дотооддоосоо 100 хувь хангаад, импортын хүнсийг халж чадвал Монголын эдийн засагт үзүүлэх ач холбогдол хэр өндөр байх вэ?

- Хамгийн том ач холбогдол нь уул уурхайгаас дан хамааралтай Монголын эдийн засгийг төрөлжүүлж, улсын ачаанаас өндөр хувьтай үүрэлцэнэ гэсэн үг. Гол үнэ цэн нь ард иргэдээ дотоодын аюулгүй хүнсээр бүрэн хангаж, импортын хүнсэнд зарцуулж буй валютын урсгалыг дотооддоо шингээнэ гэсэн үг. Цаашлаад үйлдвэрлэлд технологийн дэвшлийг ашиглаж, бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинээр ажлын байр бий болгох, улмаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн экспортод гаргахад хүрнэ. Энэ нь эргээд гадаад валютын урсгалыг бууруулах, төгрөгийн ханш чангарах, суурь үнийн тогтвортой байдлыг хангах, эцэстээ үнийн өсөлт, инфляцид эерэг



нөлөөтэй байх юм. Эдийн засгийн логик нь ерөөсөө л энэ. Монгол Улсын гадаад худалдаанд асар их эерэг нөлөө үзүүлнэ.

Сангийн яамны зүгээс “Хүнсний хувьсгал”-д ямар үүрэгтэй оролцож байна вэ?

- Манай яамны зүгээс “Хүнсний хувьсгал” цогц арга хэмжээг төсөв, санхүүгийн бодлогын түвшинд бүрэн дэмжиж, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээнд шаардлагатай санхүүжилтийг улсын төсвийн төсөлд тусган, УИХ-аар батлуулан хэрэгжүүлж байна. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2023 оны төсөвт хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэгт 135.5 тэрбум төгрөг, урсгал зардалд 86.9 тэрбум, мөн 2024 онд хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэгт шаардлагатай 122.9 тэрбум, бусад зардалд нийт 96.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган УИХ-аар батлууллаа. Үүний үр дүнд 2023 онд “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд нийт 934 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 1957 иргэн, аж ахуйн нэгжид олгож, хүүгийн зөрүүг улсын төсвөөс төлж байна. Энэ бол хүнсний үйлдвэрлэл эрхлэгчид, энэ салбарт ажиллаж байгаа олон мянган хүний хувьд эдийн засгийн бодит дэмжлэг болж чадсан.

Импортыг орлох бүтээгдэхүүн бий болгох талаар олон жил ярилаа. Гэвч дэлхийн зах зээлээс үнэтэй бүтээгдэхүүн монголчууд хэрэглэх нөхцөл бүрдээд байна гэж эдийн засагчид ярих боллоо. Үүнд та ямар байр суурьтай байна вэ?

- Эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нь улс орнуудын хувьд маш том сорилт байдаг. Өмнө нь хэлсэнчлэн цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас үүдэлтэй дэлхий нийтээрээ инфляцын өсөлттэй нүүр



“ 2023 онд 1957 иргэн, аж ахуйн нэгжид 934 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов.

тулсан. Манай улсын хувьд ч ялгаагүй, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бий болсон. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд Төв банк мөнгөний бодлогыг хатууруулж, улмаар бодлогын хүүг 6 нэгж хувиас 13 нэгж хувь хүртэл өсгөж чангаруулсан. Нэг талаараа хэрэглээг дэмжсэн зээлийг хумих зорилготой инфляцын эсрэг мөнгөний хатуу бодлогыг үгүйсгэх аргагүй юм. Гэвч нөгөө талдаа бизнес эрхлэгчдийн хувьд зээлийн хүү өссөн. Тэдний үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүний өртөг зардлыг өсгөж, цаашлаад үнэ өсөх сөрөг үр дагавартай.

Харин Засгийн газраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг санхүүжүүлэхэд зориулж ХАА-н салбарт бодит үйлдвэрлэлийг бий болгох төсөл арга хэмжээг нэн таатай нөхцөлтэй эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлээр санхүүжүүлэх бодлого хэрэгжүүлж байгаа нь үр дүнтэй байна. Шаардлагатай санхүүжилтийг арилжааны банкуудын эх үүсвэрээр шийдэж, зээлийн хүүгийн зөрүүг Засгийн газраас хариуцаж байна.

Өөрөөр хэлбэл банкуудын чөлөөт мөнгөн эх үүсвэрийг, хэрэглээг дэмжсэн зээлд зарцуулахаас сэргийлж, харин ХАА-н салбарын дотоодын үйлдвэрлэл, хүнсний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг дэмжсэн бодлого руу чиглүүлсэн гэж ойлгож болно.

Тухайлбал, жилийн 5-6 хувийн хүүтэй, тав хүртэлх жилийн хугацаатай нэн хөнгөлөлттэй зээлийг Хүнсний салбарт олгож эхэлснээр нэг талаас үйлдвэрлэлийг дэмжсэн мөнгөний нийлүүлэлт, нөгөө талаасаа хүнсний хангамж дунд болон урт хугацаандаа дорвитой нэмэгдэж, улмаар зах зээлийн зарчмаар бараа бүтээгдэхүүний өртөг зардал, үнэ буурах суурь нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм. Иймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн

санаачлан хэрэгжүүлж буй гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах, цаашлаад экспортлогч орон болох зорилтыг бүрэн дэмжиж ажиллаж байна.

Дотоодын жижиг, дунд үйлдвэрүүдийн хувьд импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөж, дотоод зах зээлээ эзэлнэ гэдэг амаргүй даваа байх. Төр засгийн зүгээс бодлогын онцгой дэмжлэг хэрэгтэй байх?

- Яг үнэн. Энэ бол дотоодын үйлдвэрлэгчдийн хамгийн том бэрхшээл. Шинээр үйлдвэрлэл эрхэлж буй бизнес эрхлэгчдийн хувьд гадны том үйлдвэрлэгчидтэй үнээр өрсөлдөх нь маш хэцүү. Бид суурь шалтгаанаа зөв оношилж, түүнд тохирсон бодлогын арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх ёстой юм. Жижиг дунд бизнес эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэлийн хүчин чадлаас хамаарч нэгж бүтээгдэхүүний өртөг зардал өндөр байх нь бий. Ер нь бол гадаад макро хүчин зүйлийн нөлөөгөөр бий болсон түр зуурын үнийн шок хэлбэлзлээс шалтгаалж, дотоодын үйлдвэрлэлээ унагааж болохгүй.





САНГИЙН ЯАМ




**Монгол Улс
хүнсний хангамжаар
“тусгаар ТОГТНОХ”
шалтгаан**

Сүүлийн жилүүдэд дэлхий нийт коронавируст халдварт /Ковид-19/ цар тахал болон Орос, Украины зэвсэгт мөргөлдөөнөөс үүдэлтэй хүнсний хомсдолд өртсөний улмаас өлсгөлөн, хүнсний аюулгүй байдлын хямралтай тулгарч байв.

Дэлхийн хүнсний зах зээлд гол нийлүүлэгч эдгээр хоёр улсын хооронд үүссэн таагүй нөхцөл байдал нь дэлхийн 82 улсын 345 сая хүн амын хүнсний аюулгүй байдалд шууд сөргөөр нөлөөлснийг НҮБ мэдээлсэн юм.

Хүнсний бүтээгдэхүүнийхээ нийт хэрэглээний 50-иас илүү хувийг импортоор хангадаг манай улсын хувьд цар тахал, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалсан хилийн хязгаарлалт, түүнийг дагасан тээвэр логистикийн хүндрэл нь хүнсний бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийг сааруулж, үнийн өсөлтийг бий болгоход нөлөөлсөн. Иймээс манай улсын хувьд хүнсний бие даасан байдал нь нэн тэргүүний зорилт бөгөөд үүнийг хэрэгжүүлэх нэг алхам нь “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөнийг орон даяар өрнүүлэх явдал юм.


ОХУ болон Украин нь дэлхийн хүнсний зах зээлд нийлүүлэлтээрээ тэргүүлэгч улсууд юм.



Монгол Улс, ОХУ-ын хүнсний импортын хамаарал



Дайны нөлөөгөөр ОХУ-аас импортолдог дээрх бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдаж, хомсдол үүссэнтэй холбоотойгоор 2021 оны 6-р сард 6.7 хувь байсан инфляцын түвшин 2022 оны 6-р сард 16.9 хувь хүртэл өссөн юм.



Дэлхийн улс орнууд хүнсний хямралыг хэрхэн даван туулж байна вэ?

- Дотоодын хүнсний зах зээлийг хамгаалах
- Импортын татварыг хөнгөлөх
- Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг дэмжих
- Хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Стратегийн голлох хүнсний бүтээгдэхүүнүүдэд экспортын хориг, квот тогтоох
- Төсвийн дэмжлэг урамшуулал олгох
- Экспортын татварыг нэмэгдүүлэх

Монгол Улсын Засгийн Газар үнэ тогтворжуулах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд дараах арга хэмжээг хэрэгжүүлэв

Шатахууны үнийг тогтворжуулав

2022.04.15-ны өдөр УИХ-аар холбогдох хуулийг баталж, Засгийн газраас баталгаа гарган хөнгөлөлттэй үнээр шатахуун импортлох гэрээ байгуулсан компаниудын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэв. Ингэснээр АИ-92 шатахууны үнийг өнөөдрийг хүртэлх хугацаанд 2,390 төгрөгт тогтвортой барив.

Хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэв

Зарим хүнсний нөөц бүрдүүлэхэд зориулж хөнгөлөлттэй зээл олгон, санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлснээр 2022 онд 12 аж ахуйн нэгжид 53.3 тэрбум төгрөгийн зээлийг махны нөөц бүрдүүлэхэд, 5 аж ахуйн нэгжид 35.2 тэрбум төгрөгийн зээлийг гурил, ургамлын тос, тэжээлийн нөөц бүрдүүлэхэд зориулж тус тус олгов.

Импортын бүтээгдэхүүний үнийн дарамтыг бууруулав

2022 онд нийт 126 аж ахуйн нэгжийн импортолсон бараа, бүтээгдэхүүнийг 12.9 тэрбум төгрөгийн гаалийн албан татвараас чөлөөлж, импортын барааны инфляцын дарамтыг бууруулав.

Макро эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээ авав

Макро эдийн засгийг тогтворжуулах бодлогын арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлснээр 2023 онд инфляцын түвшин 7.9 хувьд хүрэв.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэв

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгаар 2022 оны 6-р сараас эхлэн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг орон даяар хэрэгжүүлж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт бодлогын томоохон реформыг эхлүүлэв.



Үр дүн: 2023 оны эцэст инфляцын түвшин **7.9** хувьд хүрч буурав.



“Хүнсний хувьсгал” - Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 3 дахин нэмэгдүүлэв

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалт 2022 онд **35.5** тэрбум төгрөг байсан бол 2023 онд 2 дахин нэмэгдэж **73.4** тэрбум төгрөг болж өссөн. Харин 2024 онд **123.6** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг төсөвт тусгав.

ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2022 <small>/тэрбум төг/</small>	2023 <small>/тэрбум төг/</small>	2024 <small>/тэрбум төг/</small>
 Мал, аж ахуйг дэмжих	14.5	29.3	45.0
 Хөнгөн үйлдвэрийн дэд бүтэц	4.0	15.5	30.7
 Газар тариаланг дэмжих	7.2	16.8	27.1
 Жижиг, дунд бизнесийг дэмжих	6.9	8.5	11.3
 Бодлого, зохицуулалт болон бусад	2.9	3.4	9.5
НИЙТ	35.5	73.4	123.6


Шинээр байгуулах аж үйлдвэрийн паркууд



Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр үйлдвэрлэл, технологийн паркийг бүсчлэн хөгжүүлэхээр ажиллаж байна.

- Баруун бүс “Шинэ Ховд” ҮТП
- Төвийн бүс “Дархан арьс ширний цогцолбор” “Эмээлт” эко аж үйлдвэрийн парк
- Говийн бүс “Говьсүмбэр мал аж ахуй шинжлэх ухааны үйлдвэрлэл, технологийн парк”
- Зүүн бүс “Дорнод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк”-уудыг байгуулахаар төлөвлөв.

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



Шинэ Ховд үйлдвэрлэл технологийн парк

Баруун бүсэд “Шинэ Ховд” УТП – Төсөвт өртөг 120.4 т.б ₮



Дархан арьс ширний цогцолбор

Төвийн бүсэд “Дархан арьс ширний цогцолбор” - Төсөвт өртөг 185.7 т.б ₮






САНГИЙН ЯАМ

Гадаад зээл, тусламжаар
хэрэгжүүлж буй төсөл,
хөтөлбөрүүд

1992-2023 ОНЫ ХООРОНД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР 764.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН 87 ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭВ.



1993-2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

Санхүүжүүлэгч	Төсөл, арга хэмжээ	т.6 ₮
ДБ	Малын индексжүүлсэн даатгал төсөл	100.2
АХБ	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төсөл	47.4
Япон	Дарханы мах боловсруулах үйлдвэрийг сэргээх төсөл	59.7
ШХА	“Ногоон алт” бэлчээрийн экосистемийн менежментийн хөтөлбөр	20.0
АХБ	Малын эрүүл мэнд, мал аж ахуйн зах зээл төсөл	18.3
АХБ	Хөдөөгийн санхүүжилт	15.8
Беларусь	ХАА трактор төсөл	12.9
АХБ	Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх төсөл	12.2
БНСУ	Дорнод Монголыг хөгжүүлэх ХАА-н Мастер төлөвлөгөө боловсруулах төсөл	8.5

УИХ-ЫН 2022 ОНЫ 36 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН
“ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

Хэрэгжиж байгаа	Хэлэлцээрт	Судалж байгаа																												
6 АРГА ХЭМЖЭЭ	3 АРГА ХЭМЖЭЭ	2 АРГА ХЭМЖЭЭ																												
52.0 т.6 ₮	32.0 т.6 ₮	92.0 т.6 ₮																												
<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>т.6 ₮</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ</td> <td>0.1</td> </tr> <tr> <td>ХҮНСНИЙ НОГООНЫ УСАЛГААТАЙ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ</td> <td>10.0</td> </tr> <tr> <td>ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ</td> <td>5.0</td> </tr> <tr> <td>АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ</td> <td>13.5</td> </tr> <tr> <td>ҮР ТАРИАНЫ ЭЛЕВАТОР БАЙГУУЛАХ</td> <td>13.4</td> </tr> <tr> <td>ЖИМС, ЖИМСГЭНИЙН ТӨРӨЛЖСӨН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ</td> <td>10.0</td> </tr> </tbody> </table>		т.6 ₮	ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ	0.1	ХҮНСНИЙ НОГООНЫ УСАЛГААТАЙ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	10.0	ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ	5.0	АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ	13.5	ҮР ТАРИАНЫ ЭЛЕВАТОР БАЙГУУЛАХ	13.4	ЖИМС, ЖИМСГЭНИЙН ТӨРӨЛЖСӨН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ	10.0	<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>т.6 ₮</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>БАГА ОВРЫН ТОНОГ, ТӨХӨӨРӨМЖ ҮЙЛДВЭРЛЭХ</td> <td>1.0</td> </tr> <tr> <td>50 ГА ХҮЛЭМЖИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ</td> <td>30.0</td> </tr> <tr> <td>ӨРХИЙН БОРЛУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ</td> <td>1.0</td> </tr> </tbody> </table>		т.6 ₮	БАГА ОВРЫН ТОНОГ, ТӨХӨӨРӨМЖ ҮЙЛДВЭРЛЭХ	1.0	50 ГА ХҮЛЭМЖИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ	30.0	ӨРХИЙН БОРЛУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ	1.0	<table border="1"> <thead> <tr> <th></th> <th>т.6 ₮</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>“БИОКОМБИНАТ” ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ</td> <td>90.0</td> </tr> <tr> <td>ВАКЦИНЫ ХҮЙТЭН ХЭЛХЭЭНИЙ СҮЛЖЭЭГ БИЙ БОЛГОХ</td> <td>2.0</td> </tr> </tbody> </table>		т.6 ₮	“БИОКОМБИНАТ” ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ	90.0	ВАКЦИНЫ ХҮЙТЭН ХЭЛХЭЭНИЙ СҮЛЖЭЭГ БИЙ БОЛГОХ	2.0
	т.6 ₮																													
ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ	0.1																													
ХҮНСНИЙ НОГООНЫ УСАЛГААТАЙ ТАЛБАЙГ НЭМЭГДҮҮЛЭХ	10.0																													
ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ	5.0																													
АГРО ОЙН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ	13.5																													
ҮР ТАРИАНЫ ЭЛЕВАТОР БАЙГУУЛАХ	13.4																													
ЖИМС, ЖИМСГЭНИЙН ТӨРӨЛЖСӨН АЖ АХУЙ БАЙГУУЛАХ	10.0																													
	т.6 ₮																													
БАГА ОВРЫН ТОНОГ, ТӨХӨӨРӨМЖ ҮЙЛДВЭРЛЭХ	1.0																													
50 ГА ХҮЛЭМЖИЙН ЦОГЦОЛБОР БАЙГУУЛАХ	30.0																													
ӨРХИЙН БОРЛУУЛАЛТЫН ДЭМЖЛЭГ	1.0																													
	т.6 ₮																													
“БИОКОМБИНАТ” ТӨХХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ӨРГӨТГӨН ШИНЭЧЛЭХ	90.0																													
ВАКЦИНЫ ХҮЙТЭН ХЭЛХЭЭНИЙ СҮЛЖЭЭГ БИЙ БОЛГОХ	2.0																													

Хөгжлийн түнш байгууллага



ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ЗЭЭЛ

2023 оны жилийн эцсийн байдлаар:



Эх сурвалж: ХХААХҮЯ


Төслийн нэр	ААН-ийн тоо	Дүн т.б ₮
Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл II үе шат	988	365.0
Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл	518	138.8
Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл	7	27.0
Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	997	15.5
Экспортыг дэмжих төсөл	225	13.0
Нийт	2,735	559.4

2023 оны жилийн эцсийн байдлаар гадаадын зээл, тусламжаар хүнсний боловсруулах үйлдвэр, газар тариалангийн үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн чиглэлийн **2735** ААН-д нийт **559.4** тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна.

2024 онд хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарыг дэмжих гадаад зээл, тусламжийн 9 төсөл хэрэгжиж, 1 төсөл хэлэлцээрийн шатанд байна. Уг салбарын ААН-үүдэд олгох боломжтой санхүүжилт 345.9 тэрбум төгрөг юм.

ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ААН-ҮҮДЭД ОЛГОХ БОЛОМЖТОЙ САНХҮҮЖИЛТ

2024 онд олгох боломжтой хөнгөлөлттэй санхүүжилт



ADB Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалт-ын хөтөлбөр

- АХБ-ны 735 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл
- Хэрэгжих хугацаа 2023-2033

2024 онд олгох санхүүжилт **194.9 т.б ₮**

ADB Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төсөл

- АХБ-ны 60 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл
- Хэрэгжих хугацаа 2016-2024

2024 онд олгох санхүүжилт **83.3 т.б ₮**

JICA Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл

- Япон, ЖАЙКА-ын 34 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл
- Хэрэгжих хугацаа 2011-2026

2024 онд олгох санхүүжилт **18.0 т.б ₮**

THE WORLD BANK МАЛ АЖ АХУЙН САЛБАР-ын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл

- ДБ-ны 30 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл
- Хэрэгжих хугацаа 2020-2025

2024 онд олгох санхүүжилт **20.3 т.б ₮**

ADB Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил 2 төсөл

- АХБ-ны 57.1 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл
- Хэрэгжих хугацаа 2024-2026

2024 онд олгох санхүүжилт **29.4 т.б ₮**

ХАА-н салбарт гадаад зээл, тусламжаар хэрэгжих онцлох төслүүд

“АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ



Монгол Улс, Азийн хөгжлийн банктай хамтран “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг Уур амьсгалын ногоон сан, Европын хөрөнгө оруулалтын банкны хамтын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

15 аймгийн төв, 34 сумын төвд хөтөлбөр хэрэгжинэ

Тус хөтөлбөрийн хүрээнд Эдийн засаг, Хөгжлийн Яамнаас хөдөө аж ахуйн логистик, ханган нийлүүлэлтийн төв, үйлдвэр болон кластерын зориулалттай байршлуудыг тодорхойлж, Азийн хөгжлийн банкны зүгээс тодорхойлсон байршлуудад харьцуулалт хийж, нийт 15 аймгийн төв болон 34 сумын төвд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр сонгосон.

Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр хэрэгжсэнээр хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тохиромжтой эхний 15 аймгийг сонгож, цаашид гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай дэд бүтэц, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх нөхцөл боломж бүрдэх юм.

1
Аймаг, сумын төвүүдийн дулаан хангамж, ус зайлуулах хоолой, бохир усны шугамыг шинээр барина. /395.7 сая \$/.

3
Агро-бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл олгох, хүртээмжийг нэмэгдүүлэх /117.6 сая \$/.

2
Хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, бэлчээрийн доройтлыг арилгах, сүргийн бүтцийг чанаржуулах /99.2 сая \$/.

4
Хөтөлбөрт оролцогчдын чадавхыг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрийн паркийн менежменттэй холбоотой төрхувийн хэвшлийн түншлэлийн зохицуулалтыг судлах /38.5 сая \$/.



“Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 1-р үе шатыг санхүүжүүлэх 140 сая ам.долларын зээл, 28 сая ам.долларын буцалтгүй тусламжийн гэрээг үзэглэв. /2024.01.11/



Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн эхний санхүүжилт болох 54.4 сая еврогийн зээл, буцалтгүй тусламжийн хэлэлцээрийг баталгаажуулав. /2024.03.12/



**ХҮНСНИЙ НОГООНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ БА
УСАЛГААТАЙ ГАЗАР ТАРИАЛАНГ ДЭМЖИХ ТӨСӨЛ
/2020-2027/**



Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төслийн хүрээнд дараах ажлуудыг хийнэ.

Усалтын системийг шинэчлэн сайжруулж, усны хэмнэлттэй, дуслын усалгааны технологийг



нутагшуулна. Ингэснээр усалгаатай тариалангийн талбайн хэмжээг 7.0 мян.га-аар нэмэгдэнэ.

Газар тариалангийн 4 хүрээлэнгийн усалтын системийг сэргээн засах, үр үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлнэ. Үр дүнд хүнсний ногоо, үр тариа, тэжээлийн таримлын үр үйлдвэрлэл 1,8 тн-оор нэмэгдэх юм.

Ногоочдын хоршооны чадавхыг сайжруулж, хүлэмж, зоорь байгуулах, техник, тоног төхөөрөмж олгох бөгөөд 3,458 өрх төслийн үр ашгийг шууд байдлаар хүртэж, шинээр 3000

иргэн хүнсний ногооны тариалалт эхлүүлэх боломжтой болно.

Төсөлд:

- 7 аймгийн 11 сум
- 3548 хүнсний ногооны тариалан эрхлэгч өрх
- Ургамал газар тариалангийн хүрээлэн
 - Дархан-Уул аймаг, Хонгор сум
 - Увс аймаг, Улаангом сум
 - Сэлэнгэ аймаг, Зүүнхараа сум
 - Дорнод бүсийн Сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн хүрээлэн
- Ургамал хамгааллын ЭШХ
- ХХААХҮЯ-ны Судалгаа хөгжлийн төв хамрагдана.

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ-2”
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БЭЛТГЭЛ АЖЛЫГ
ХАНГАЖ БАЙНА**

Тус төслийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр хэлэлцээр хийж байгаа бөгөөд төслийн хүрээнд хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрүүдийн хөгжлийг дэмжих үүднээс хөрөнгө оруулалтын дэд зээлүүдийг үргэлжлүүлэн олгоно. Нэмэлт санхүүжилтийн дагуу малчид, фермерүүд, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны нийлүүлэгчдийн чадамжийг бэхжүүлэх, ажил, бараа, үйлчилгээ олгох замаар үйлдвэрлэлийн чадамж, ашиг орлогыг нэмэгдүүлэх юм.

ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ

Нэг зээлдэгчид 2.0 - 8.0 тэрбум төгрөг

Жилийн 8%-иас хэтрэхгүй хүүтэй

7 хүртэлх жилийн хугацаатай
эхний 3 жил хүртэлх хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөх



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ ЗАМААР ЭДИЙН ЗАСГИЙГ ТӨРӨЛЖҮҮЛЖ, АЖЛЫН БАЙРЫГ БИЙ БОЛГОХ ТӨСӨЛ

Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, бизнесийн тогтвортой үйл ажиллагааг сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгоно.



Төслийн хүрээнд нийт 542 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид 151.8 тэрбум төгрөгийн батлан даалтын санхүүжилт олгосон. Үүний үр дүнд 2,726 ажлын байр шинээр бий болж, 5,049 ажлын байр хадгалагдсан байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨСӨЛ 2-р үе шат


Аж үйлдвэрийг төрөлжүүлж, бус нутгийн хөгжлийн стратегийг бэхжүүлснээр дунд болон урт хугацаанд хүрээлэн буй орчинтой зохицсон, эдийн засгийн тэнцвэртэй өсөлтийг хангана.



Төслийн үр дүнд ЖДҮ эрхлэгчдийн 990 бизнесийн төслийг 365 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж нийт 27,010 гаруй ажлын байр шинээр бий болгов.

МАЛ АЖ АХУЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Мал сүргийн эрүүл мэнд, бүтээмж, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.



Төслийн байршил: Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв, Хэнтий болон Дундговь аймгийн 80 сум

ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлнэ.



Төслийн хүрээнд түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан 225 ААН-үүдэд нийт 12.9 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов.

“Хүнсний хувьсгал” - Үйл ажиллагааны зардалд 183 тэрбум төгрөг батлав



Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын дагуу 2023 онд нийт **86.8** тэрбум төгрөг, 2024 онд нийт **96.5** тэрбум төгрөг батлав.

I. Хүнсний үйлдвэрийг хөгжүүлэх:

2023 онд **150.0** сая.₮,
2024 онд **147.2** сая.₮
тус тус баталсан.

- “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг сурталчлах

II. Мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх

2023 онд **3.2** т.б.₮, 2024 онд **4.5** т.б.₮
тус тус баталсан.

- Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх

III. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ

2023 онд **41.6** т.б.₮, 2024 онд **41** т.б.₮

- Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт дархлаажуулалт

2023 оны жилийн эцсийн байдлаар 18 нэрийн вакцинд давхардсан тоогоор 33.1 сая толгой мал, амьтныг дархлаажуулалтад хамруулж, 98%-тай гүйцэтгэсэн байна.



IV. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх

2023 онд **38.4** т.б.₮, 2024 онд **50** т.б.₮

- Хөрсний үржил шимийг сайжруулах, хүнсний үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэх

V. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх

2023 онд **2** т.б.₮, 2024 онд **981** сая.₮

- Мал малын гаралтай түүхий эд, бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын сүлжээг бий болгох

VI. Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ

2023 онд **1.5** т.б.₮, 2024 онд **98.1** сая.₮

- Тариалангийн талбайн хөнөөлт организмын тандалт, тархалтын судалгаа хийх



2023 онд хөдөө аж ахуйн салбарт 832 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгов

Монгол Улсын Засгийн газраас “Хүнсний хувьсгал” цогц арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлд 342.6 тэрбум төгрөг, мал аж ахуйн үйлдвэрлэлд 132.3 тэрбум төгрөг, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 507.1 тэрбум төгрөг, нийт 982 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг дараах нөхцөлөөр олгохоор шийдвэрлэсэн. Үүнд:

1,956 иргэн, аж ахуйн нэгжид нийт 832.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд эргэлтийн хөрөнгийн зориулалтаар 1,589 иргэн, аж ахуйн нэгжид 408 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын зориулалтаар 367 иргэн, аж ахуйн нэгжид 424.7 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгов.

Газар тариалангийн үйлдвэрлэлд 216.8 төгрөгийн зээлийг 1,379 иргэн, аж ахуйн

ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ЗЭЭЛ

3 хүртэлх жилийн хугацаатай, Зээлийн хүү нь жилийн

5%

Зээлийн хүү нь жилийн 18% бөгөөд үүнээс Засгийн газар 13%-ийг хариуцан төлж, зээлдэгч иргэн, аж ахуйн нэгж 5%-ийг төлнө.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗЭЭЛ

5 хүртэлх жилийн хугацаатай, Зээлийн хүү нь жилийн

6%

Зээлийн хүү нь жилийн 19% бөгөөд үүнээс Засгийн газар 13%-ийг хариуцан төлж, зээлдэгч иргэн, аж ахуйн нэгж 6%-ийг төлнө.

Засгийн газар төлөх зээлийн хүүгийн зөрүүнд 2023 оны улсын төсөвт 135.5 тэрбум төгрөг, 2024 оны улсын төсөвт 122.9 тэрбум төгрөгийг тусган батлуулав.


Үр дүн: Хүнсний хувьсгалын хүрээнд 2023 онд нийт 982 тэрбум төгрөгийн зээл олгохоос

нэгжид, мал аж ахуйн үйлдвэрлэлд 54.2 тэрбум төгрөгийн зээлийг 140 иргэн, аж ахуйн нэгжид, хүнсний боловсруулах үйлдвэрлэлд 561.7 тэрбум төгрөгийн зээлийг 437 иргэн, аж ахуйн нэгжид тус тус олгоод байна.

Дээрх хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын эх үүсвэрээр олгосон бөгөөд зээлийн хүүгийн зөрүүнд 2023 онд 26.4 тэрбум төгрөгийг олгосон байна.

2024 онд олгох зээл: Хүнсний хувьсгалын хүрээнд 2024 онд арилжааны банкуудын эх үүсвэрээр шинээр 300.0 тэрбум төгрөгийг олгох бөгөөд хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 137.5 тэрбум төгрөг, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 106.0 тэрбум төгрөг, мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 56.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгож байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр **56.5 т.6 ₮**



Хүнсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр **137.5 т.6 ₮**

Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр **106 т.6 ₮**



САНГИЙН ЯАМ



Татварын
бодлого



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДЭД ЧИГЛЭСЭН ТАТВАРЫН БОДЛОГО

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой хөгжлийг ханган, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах, хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ” гэж заасан.

Энэ зорилгын хүрээнд Засгийн газар иргэн, аж ахуйн нэгжийг орон нутагт газар тариалан эрхлэхэд татварын таатай орчныг бий болгох зорилгоор зарим татварыг хөнгөлөх, чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлж байна.

Үр дүнд нь тариалангийн үйлдвэрлэлийн өсөлтийг тогтворжуулж, тариаланчид, үйлдвэрлэгчдийн эдийн засгийн чадамжыг сайжруулан, иргэдээ эрүүл аюулгүй, дотоодын хүнсээр хангах нөхцөл бүрдэж байна.

Импортолж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, ойн аж ахуйн техник, бордоо, ургамал хамгааллын бодисыг НӨАТ-аас чөлөөлөв.

Үр тариа, төмс, хүнсний ногоо, сүү, жимс, жимсгэнэ, тэжээл, тэжээлийн ургамал тариалсан, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн эрчимжсэн тахианы аж ахуйн орлогын албан татварыг 50 хувиар хөнгөлөв.

НӨАТ-аас чөлөөлөв

50% -иар

100% -иар

100% -иар

90% -иар

2027 он хүртэл

Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлөв.

Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын гаалийн албан татвараас чөлөөлөв.

Импортын болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг НӨАТ-аас чөлөөлөв.

Газар тариалан эрхлэгчдийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурилыг НӨАТ-аас 100 хувь чөлөөлөв.

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн, дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүнийг НӨАТ-аас 100 хувь чөлөөлөв.

100% -иар



Хөдөө аж ахуйн боловсруулах болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр барихад зориулан импортолж байгаа техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдлийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 2 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх болов.

ДОТООДЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧДИЙГ ТАТВАРЫН БОДЛОГООР ДЭМЖИХ ЧИГЛЭЛД:

20 ХУВИАР

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ААН ажил хайгч иргэнийг ажилд авсан тохиолдолд олгосон цалингийн зардлыг нэмэгдүүлэн татвар ногдох орлогоос хасаж тооцно.

100 ХУВИАР

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэл борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг НӨАТ-аас чөлөөлөв.

- Дотооддоо түүхий эд боловсруулж, дотооддоо борлуулсан сүү, сүүн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөв.

- Улаанбаатар хотоос 500 км-ээс хол алслагдсан аймаг, суманд үйл ажиллагаа эрхэлсэн ААН-ийн төлөх татварыг 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан бол 90 хувиар тус тус хөнгөлөв.

- Багануур, Багахангай, Налайх дүүргээс бусад дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг ААН үйлдвэр, агуулахаа орон нутагт нүүлгэсэн тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг 50 хувиар нэмэгдүүлэн тооцож татвар ногдох орлогоос хасна.

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ”-ЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖИЖ БУЙ ТАТВАРЫН ДЭМЖЛЭГ



НИЙТ 15 АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЖ

ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИД НИЙТ

120

гаруй т.б ₮-ийн

ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТИЙГ ҮЗҮҮЛЭЭД БАЙНА.

Хүнсний хувьсгал - Хууль, эрх зүйн орчны сайжруулалт

Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан:



Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг цаашид зах зээлээр нь дэмжих бодлого барина.



• “Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хуулийг 2022.07.05-ны өдөр шинэчлэн баталж, ҮТП-ийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлөх, ҮТП-ийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлөв.

• “Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 19 дүгээр тогтоолыг батлав.

• “Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай” хуулийг 2022.11.11-ний өдөр баталж, хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 он хүртэл 100 хувь хөнгөлөв.

• Засгийн газрын 2022 оны 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг батлав. Уг техникийн зохицуулалтаар улсын хилээр угаасан бус самнасан ноолуурыг нэвтрүүлэх зохицуулалтыг тусгасан юм.







• “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд ноос ноолуур, арьс шир бэлтгэл, үйлдвэрлэлд зориулан 2021 онд 110, 2022 онд 190 хүртэл тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкны эх үүсвэрээр бүрдүүлэх, зээлийн нийт хүүгийн 7.65 нэгж хувийг 2021 онд, 10.65 нэгж хувийг Засгийн газар төлөхөөр тусгав.

• УИХ-ын 2023 оны 87 дугаар тогтоолоор “Хонины ноосны килограмм тутамд 1000 төгрөг, тэмээний ноосны килограмм тутамд 2000 төгрөг, сарлагийн хөөврийн килограмм тутамд 10000 төгрөгийн урамшуулал олгох”-оор тусгав.

• Засгийн газрын 2023 оны 64 дүгээр тогтоолоор арилжааны банкнуудын эх үүсвэрээр ноолуурын үйлдвэрүүдэд хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээг Монгол банкт хамтран зохион байгуулж байна.

Хүнсний хувьсгал - Түүхий эдийн үнэ цэн ба урамшуулал

Ноос, арьс шир, сүү, улаанбуудай, хүнсний ногоог үндэсний үйлдвэрт бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох тухай Монгол Улсын Засгийн газраас баталсан журмуудын дагуу жил бүр мөнгөн урамшуулал олгож байна.

	сая төгрөг				
					
АЙМАГ	НООС	АРЬС, ШИР	СҮҮ	УЛААН БУУДАЙ	ХҮНСНИЙ НОГОО
Архангай	472.5	354.9		120.5	1.5
Баян-Өлгий	766.5				
Баянхонгор	98.4	8.6			
Булган	107.9	28.3	108.5	1,495.6	7.1
Говь-Алтай	198.5	11.8			
Говьсүмбэр	122.3	6.6			
Дархан-Уул	3.1		31.0	523.9	2,093.3
Дорноговь	579.5	1.2			
Дорнод	153.6	37.1		859.7	3.1
Дундговь	159.1				
Завхан	677.0	167.1			1.2
Орхон	9.3	0.2	0.7	488.5	160.0
Өвөрхангай	168.3	4.2		67.8	0.1
Өмнөговь	234.8	19.3			
Сүхбаатар	421.6	127.6		96.2	2.6
Сэлэнгэ	125.5	0.9	1,198.3	7,379.9	2,738.2
Төв	461.2	300.7	1,615.7	1,434.0	433.7
Увс	333.0			198.9	100.4
Улаанбаатар	10.0	1.0	2,082.3	407.5	149.2
Ховд	229.4				45.5
Хөвсгөл	838.8	88.8		269.5	24.1
Хэнтий	286.1	89.6		449.5	83.5
НИЙТ	6,456.4	1,247.7	5,036.5	13,791.5	5,843.4

ХАА-Н САЛБАРТ ОЛГОХ УРАМШУУЛЛЫГ ХОЁР ДАХИН НЭМЭГДҮҮЛЭВ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	2023 оны гүйцэтгэл т.б ₮	2024 оны төсөв т.б ₮	Урамшуулал тооцох
1	Улаан буудайн урамшуулал	13.8	16.7	Тонн тутамд 80.000₮
2	Сүүний урамшуулал	5.0	15.0	Түүхий шингэн сүүний литр тутамд 1000₮
3	Арьс, ширний урамшуулал	1.2	11.5	Бог малын арьс тутамд 3000₮, адуу, үхрийн ширэнд 15,000₮
4	Ноосны урамшуулал	6.4	23.8	Хонины ноос-1500₮, тэмээний ноос-2000₮кг тутамд
5	Хүнсний ногооны урамшуулал	5.8	9.9	Хүнсний 10 нэр төрлийн ногооны 1тн тутамд 100,000₮
6	Үнийн хөнгөлөлт	6.8	8.3	Үнийн дүнгийн 30-50%-ийн буцаан олголт





“Хүнсний хувьсгал” - Бусад орнуудад...

Дэлхийн улс орнууд хүнсний аюулгүй байдлаа хангахад чиглэсэн төрөл бүрийн төсөл хөтөлбөр санаачилж, хөдөө аж ахуйн салбарын санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлсээр байна.

КАЗАХСТАН УЛС:

Казахстан улсын Засгийн газар нь 2022-2024 онд “Хүнсний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г баталжээ. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд тариаланчид болон малчдад хөнгөлөлттэй



зээл, татаас олгох, хөдөө аж ахуйн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж байна.

2023 оны байдлаар “Хүнсний аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө”-нд 2.7 тэрбум ам.доллар буюу нийт төсвийн зардлын 4 хувийг зарцуулсан байна.

ВЬЕТНАМ УЛС:

Хүнсний хувьсгалын хүрээнд газар тариалан эрхлэгчдийн үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн газар шинэчлэл, усалгааны дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг түлхүү хэрэгжүүлдэг.

Хүнсний хувьсгалын хөтөлбөрүүдийн санхүүжилтийн 40-60 орчим хувийг улсын төсвөөс олгодог бол жижиг фермер эрхлэгчдийн үйлдвэрлэлийг гадаадын зээл тусламжийн ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ №4 | Хөрс эрүүл бол хүнс эрүүл



хөтөлбөрөөр дэмждэг байна.

ХЯТАД УЛС:

Хүнсний бүтээгдэхүүний 80 орчим хувийг бүрдүүлдэг 250 сая жижиг аж ахуй эрхлэгчдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагаагаар хүрч ажиллаж байна.

Ингэхдээ цахим худалдааны платформ болон дижитал технологийг ашигладаг бөгөөд хувийн хэвшлийн хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, түгээлтийг хөнгөвчлөхийн тулд онлайн систем, цахим худалдааны логистикийн сүлжээ, дижитал төлбөрийн системийг хөгжүүлэх санаачилгуудыг дэмжиж хамтран ажилладаг аж.

ЭНЭТХЭГ УЛС:

Хүнсний салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих бодлого, эрх зүйн орчныг зохицуулах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн татварын хөнгөлөлт, татаас олгоход ихээхэн анхаардаг.

Хүнсний салбарын судалгаа шинжилгээг эрчимжүүлж, хүнсний тэжээллэг чанарыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарын шинэ технологи хөгжүүлж практикийг сайжруулах чиглэлд хувийн хэвшилтэй нягт уялдаатай хамтран ажилладаг.

Хүнсний хувьсгал - Монгол Улсад ...

Монгол Улс 1 тэрбум гаруй ам.доллаароор хилийн чанадаас хүнсний бүтээгдэхүүн худалдаж авдаг байсан бол “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн хэрэгжсэнээр 2023 онд 120 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломжийг бүрдүүлж чадлаа. Мөн онд хүнсний бүдүүн ногоогоор дотоодын хэрэгцээгээ түүхэндээ анх удаа 85 хувь хангав.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөн нь:

1 Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах

2 Удирдлага зохион байгуулалт

3 Газар тариалангийн үйлдвэрлэл

4 Мал аж ахуйн үйлдвэрлэл

5 Хүнсний боловсруулах үйлдвэрлэл чиглэлд хөгжүүлж байна

Дэлхий дахинд үүсээд буй нөхцөл байдал, цар тахал, тээвэр логистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэргээс шалтгаалсан хүнсний хангамж, аюулгүй байдал улс орон бүрийн нэн тулгамдсан сорилт хэвээр байгаа өнөө үед манай улс хүнс,

хөдөө аж ахуйн салбараа дэмжин хөгжүүлж, дотоодын хүнсний хангамж, аюулгүй байдлаа хангах боломж бүрдэж байна. Цаашлаад хүнсний бүтээгдэхүүний экспортлогч болох том амбицтайгаар хамтдаа хичээж буй юм.



НҮБ-ын ХХААБ-ын Монгол дахь суурин төлөөлөгч Винод Ахужа:

“Дотоодын хүнсний үйлдвэрлэлийг өргөжүүлэх, дэлхийн хүнсний хангамжид хувь нэмэр оруулах нь үнэхээр эрхэм бөгөөд гайхалтай хүсэл эрмэлзэл гэж би бодож байна. НҮБ-ын ХХААБ энэ зорилгыг бүрэн дүрэн дэмжиж байгаа. Энэ хүсэл тэмцүүлийг биелүүлэх асар их нөөц боломж Монголд бий.

**ӨРХ БҮЛЭЭРЭЭ ХҮНС ҮЙЛДВЭРЛЭГЧ, УЛС
ОРНООРОО ХҮНС ЭКСПОРТЛОГЧ БОЛОХ ЗОРИЛГОД
ТӨР ЗАСАГ, АРД ТҮМНЭЭРЭЭ НЭГДЭЖ, НЭГЭН
СЭТГЭЛЭЭР ХАМТРАН ЗҮТГЭЦГЭЭ.**



“Бодиос”
брэндийн цйлдвэр
/2024.04.04/.



“Мон-Ирээдүй” ХХК /2024.04.04/.



“Хүн од” ХХК /2023.02.07/.



“Өгөөмж архад” ХХК
/2023.02.07/.



Төв аймгийн
Баянчандмань,
Борнуур сум
/2023.05.16/.

“Эко Пак Монгол” ХХК
/2023.02.07/.



“Улаанбаатар гурил” ХХК
/2023.05.16/.



Малчдын
НДШ-ийн

50%-ийг
төр хариуцна.

Малчдын борлуулсан
малын гаралтай түүхийг
эдийг

НӨАТ-аас чөлөөлж,
НӨАТ-ын тайлан
шаардахгүй.

Ноос, сүү, газар
тариалан, арьс ширний
урамшууллаас ЭМД
болон НДШ-ийг

өөрийн хүсэлтээр
төлнө.

Малын тоо толгойн
албан татварыг ТЕГ-аас
тооцоолж

цахимаар
хүргүүлнэ.



Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
тамгын газар

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АХЛАХ ЗӨВЛӨХ
Сүрэнжавын **ЛҮНДЭГ**

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт баялаг бүтээгч, хүнс үйлдвэрлэгч та бүхэндээ энэ сайхан өдрийн мэндийг өргөн дэвшүүлье!

Аливаа улс орны аюулгүй байдлын нэгэн суурь баталгаа бол ард иргэдийн хүнсний найдвартай, хүртээмжтэй, тогтвортой хангамж, аюулгүй байдал билээ.

Ийм ч учраас Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх эх орондоо “Хүнсний хувьсгал”-ыг өрнүүлж, ирэх таван жилийн хугацаанд гол нэр төрлийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, улмаар бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох санаачилга гарган ажиллаж байна.

Энэхүү санаачилгыг манай төр засаг, түмэн олон санал нэгтэй дэмжиж, УИХ, Засгийн газар зохих тогтоол шийдвэрийг цаг алдалгүй гаргаж, бүх нийтээрээ хүчээ нэгтгэн хамтран хэрэгжүүлж байна.

Үүний үр дүнд, өнгөрсөн хугацаанд хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч 1857 иргэн, аж ахуй нэгжид 5-6 хувийн хүүтэй, нийт 675 орчим тэрбум төгрөгийн зээлийг дотоодын арилжааны 10 банкаар дамжуулан олгож, бага хүүтэй, урт хугацааны санхүүжилтээр дэмжлээ.

Мөн хүнс, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлд нэн шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжид гааль, татварын хөнгөлөлт үзүүлж, нийт 19 үйлдвэрлэлд нэн шаардлагатай 428 төрлийн тоног төхөөрөмж хамрагдлаа.

Төр засгаас хүнс үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийнхээ үйл ажиллагааг дэмжихэд

шаардлагатай хууль эрх зүй, бодлого шийдвэр, дүрэм, журам болон бусад холбогдох арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Төр, хувийн хэвшил хамтран ажилласны үр дүнд 19 гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл тодорхой хувиар нэмэгдэж, жилдээ манай улс дотоодын хүнсний хэрэгцээнийхээ 50 орчим хувийг гаднаас авч үүнд 1.0 тэрбум гаруй ам.доллар зарцуулдаг байсан бол өмнөх оны мөн үеэс 12 хувиар бууруулж, 120.0 сая орчим ам.долларыг эх орондоо үлдээх боломжтой боллоо.

Цаашид Та бид хүрсэн амжилтаа бататган бэхжүүлж, “Хүнсний хувьсгал”-аа бүрэн хэрэгжүүлж, төр засгаас хүнс үйлдвэрлэгч, баялаг бүтээгч ард иргэд, аж ахуйн нэгжээ үргэлжлүүлэн бүх талаар дэмжиж, төр-хувийн хэвшлийн түншлэлээ улам сайжруулж, сэтгэл зүтгэлээ нэгтгэн хамтран ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөнүүд нь өөр хоорондоо нягт уялдаатай, үр дүнтэй хэрэгжсэнээр манай улсын тогтвортой хөгжлийн үндэс суурь бүрдэх учиртай.

Бүх нийтийн хамтын хичээл зүтгэл монголчууд биднийг өрх бүлээрээ хүнс үйлдвэрлэгч, улс орноороо хүнс экспортлогч болох зорилгод хүргэх болно.

Монгол эх орны минь хөрс үржил шимтэй, хүнс нь амин дэмтэй, монгол хүмүүн эрүүл саруул байх болтугай.

Төрийн тэргүүний айлчлалууд
үндэсний үйлдвэрлэгчдэд дэлхийн
зах зээлд гарах “гүүр” болов



Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
тамгын газар

FRANCE



1252 онд Людовик IX хааны зарлигаар Францын Эзэн хааны элчин төлөөлөгчөөр Виллиам Дэ Рубрук Их Монгол улсын нийслэл Хархорумд анх ирсэн нь манай хоёр улсын түүхэн хэлхээний эхлэл байв. Энэ үеэс хойш 771 жилийн дараа хоёр улс хамтын ажиллагааны шинэ хуудсыг нээлээ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ЭММАНУЭЛ МАКРОНЫ УРИЛГААР 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-14-НИЙ ӨДРҮҮДЭД ФРАНЦ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Хоёр улсын Ерөнхийлөгчид анх удаа харилцан төрийн айлчлал хийсэн нь түүхэн үйл явдал боллоо.

Айлчлалын үеэр БНФУ-ын Ерөнхийлөгч Эммануэл Макрон:

- “Хөгжлийн түлхүүр болсон хүүхэд багачуудын хооллолт, хүнсний асуудлаар дэлхийн хүнсний хөтөлбөртэй хамтран ирэх долоо хоногт Парисын сургуулийн сурагчдын хооллолтын талаарх сэдэвт хурал зохион байгуулах гэж байгаа бөгөөд танай улсын энэ салбарыг дэмжиж буйгаа илэрхийлье” хэмээсэн.



2023.10.12.
(БНФУ, Парис хот
Элизейн ордон)



Энэ хүрээнд НҮБ-ын Дэлхийн хүнсний хөтөлбөрийн санаачилгаар Франц, Финланд тэргүүтэй гишүүн орнуудын “Сургуулийн хоолны эвсэл”-д Монгол Улс нэгдэн гишүүнээр элсэж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Удийн цай хөтөлбөрийг боловсронгуй болгох, бусад улс орнуудын Засгийн газар болон судалгаа шинжилгээний хүрээлэн, иргэний нийгэм, ТББ-тай хамтран хүнсний системийг боловсронгуй болгоход хамтран ажиллаж эхэллээ.



2023.05.21. (Монгол Улс,
Улаанбаатар хот)



2023.10.12. Монгол Улсын Соёлын
элч-Марин хуурын чуулга
Версалийн ордны Хааны дуурийн
театр (БНФУ, Парис хот)



Энэхүү төрийн айлчлалын хүрээнд хоёр улсын хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:



Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр



Монгол Улсын Засгийн газар болон “Орано майнинг” компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протокол

Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр



Бүгд Найрамдах Франц Улсын Геологи уул уурхайн судалгааны товчоо, Францын геофизикийн ерөнхий компани болон Монголын үндэсний геологийн алба хоорондын эрмэлзлийн захидал

Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон БНФУ-ын “Thales Alenia Space” компанийн хоорондын Харилцан ойлголцлын тухай санамж бичиг



Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай чиглэлээр хамтран ажиллах тухай Францын Геологи, уул уурхайн судалгааны товчоо болон Монголын Үндэсний геологийн алба хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг

БИЗНЕС ФОРУМ:

Айлчлалын бүрэлдэхүүнд хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, инженер технологи, уул уурхай гэх мэт салбарын 70 орчим байгууллагын 100 гаруй бизнес эрхлэгчид багтсан бөгөөд энэ удаагийн айлчлалаас эхлэн



бизнес форум болон бизнес тур арга хэмжээг хослуулан зохион байгуулдаг шинэ жишиг тогтлоо. “Франц-Монгол бизнес форум”-д Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх биечлэн



оролцож, нээлтийн үг хэллээ.

Энэхүү форумд хоёр улсын 200 гаруй бизнес эрхлэгчид оролцон, зарим аж ахуйн нэгжүүдийн хооронд хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурж, хоёр талын бизнесийн төлөөлөгчид худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны талаар чөлөөт уулзалт хийв.

Францын нийт 66 компани манай улсад бүртгэлтэй байгаа бөгөөд тэдний хөрөнгө оруулалтын 80 орчим хувь нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулсан байна. Хоёр орны эдийн засгийн харилцан ашигтай, хамтын ажиллагааг солонгоруулан хөгжүүлэхэд тус бизнес форум чухал нөлөө үзүүлсэн юм.



2023.10.11. (БНФУ, Парис хот Нийтийн аж ахуйн үндэсний холбооны байр)



XXI зуунд дэлхий энхтайван, эв нэгдэл рүү тэмүүлэхээс гадна шинжлэх ухаан, технологийн ололтуудаа зөв зүйд ашиглахыг зорьж байна. Энэ цаг үед улс орон хөгжин цэцэглэх, амар тайван амьдрах нь гадаад харилцааны уур амьсгал, баримталж буй бодлоготой нягт холбоотой.

Асар их үнэ цэнээр бидэнд үлдсэн эх орон гэх үнэт зүйлээ өнгөлж, тордож, дэлхий дахинд эерэг дүртэй дараагийн үедээ үлдээх нь монгол хүн бүрийн үүрэг.

Дэлхий дахин энх тайванд тэмүүлсэн ч улс хоорондын зөрчил, хүн төрөлхтөнд тулгамдаж буй асуудлууд гарсаар байна.

Нөхрийн хэрэг бүтвэл, өөрийн хэрэг бүтнэ гэдэг шиг монголчууд дэлхий дахинд, хүн төрөлхтөнд тулгамдаж буй асуудлуудыг шийдэхэд хувь нэмэр оруулж, гадаад харилцаагаа өргөтгөн хөгжүүлэх цаг ирсэн.

Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч

У.Хүрэлсүх гадаад харилцаа, хамтын ажиллагааг эерэгжүүлэх олон алхам хийж буй юм. Тэрээр Монгол Улсын төрийн тэргүүнээр сонгогдоод хоёр жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд олон улсын хурал уулзалтад идэвхтэй оролцон, дэлхийн хөгжлийн дүр зургийг тодорхойлогч улс орнуудтай төрийн түүхэн айлчлалуудыг хийж Монгол гэдэг улс энэ дэлхийд оршин тогтнож, хүн төрөлхтний төлөөх үйлсэд манлайлж буйг сануулсаар байна.

Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд одоогийн эрчээрээ ажиллавал Монгол Улсын гадаад харилцаанд томоохон сэргэлт бий болох нь тодорхой гэдгийг салбарын мэргэжилтнүүд онцолж байв.

Мөн энэ удаагийн айлчлалууд харилцан ашигтай нөхцөлийг санал болгосон, хамтран ажиллах томоохон гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурж, хамтын ажиллагааг эхлүүлсэн, дотоодын үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийнхээ хүрээг тэлсэн, эдийн засаг, улс төр болон олон улсын тавцан дахь Монгол Улсын нэр төрийг өргөсөн айлчлалууд болов.



2023.04.24

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, гэргий Л.Болорцэцэг нарын урилгаар Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда гэргий Агата Корнхаузер-Дудагийн хамт төрийн айлчлал хийв.



2023.05.21

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон Монгол Улсад төрийн айлчлал хийв.



2023.07.04

Бүгд Найрамдах Энэтхэг Улс цахим хэлбэрээр зохион байгуулсан Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд хэлсэн үгэндээ “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний талаар тэмдэглэж, хамтран ажиллахад бэлэн байгааг дурдав.



2023.07.09

Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров Монгол Улсад хүрэлцэн ирэв.



2023.09.15

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Бүгд Найрамдах Куба Улсын Ерөнхийлөгч Мигель Марио Диаз-Канел Бермудезтай уулзлаа.



2023.07.24

Итали Улсын нийслэл Ром хотноо НҮБ-ын Дэлхийн хүнсний аюулгүй байдлын талаарх дээд хэмжээний уулзалтад оролцов.



2023.09.01

Гэгээн Ширээт Улсын төрийн тэргүүн Пап Францис Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар айлчлал хийв. Түүхэнд тодоор тэмдэглэгдэн үлдэх энэ айлчлал хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монгол Улсын гуравдагч хөршийн болон энх тайванч гадаад бодлого, үйл ажиллагааг бататгах ач холбогдолтой.



2023.09.21

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд үг хэлэв.



2023.10.18

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний гурав дахь удаагийн чуулга уулзалтад оролцов.



2023.10.19-20

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх БНХАУ-ын Ниншя хотон үндэстний Өөртөө засах оронд зочиллоо.

2023.12.02

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Далайд гарцгүй хөгжиж буй орнууд дахь уур амьсгалын өөрчлөлтийн өвөрмөц сорилт, бэрхшээлийг түншлэлийн замаар шийдвэрлэх нь” сэдэвт өндөр түвшний хуралдаанд оролцож үг хэллээ.




2023.12.02

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцов.



2023.11.06. Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн ордон (Вьентьян хот)

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлитийн урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд тус улсад төрийн айлчлал хийлээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад хийж буй төрийн айлчлалын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны дараах баримт бичгийг байгуулав.



Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНАЛАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хооронд хамтран ажиллах санамж бичиг




Ургамал хамгаалал, хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр



Мал эмнэлэг, мал амьтны хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр

Байгалийн нөөц, байгаль орчныг хамгаалахад хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Байгалийн нөөц, байгаль орчны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг

Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёлын яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг



Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын хэлэлцээр





Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх гэргий Лувсандоржийн Болорцэцэгийн хамт Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Во Ван Тьенг-ийн урилгаар 2023 оны 11 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд Вьетнам Улсад төрийн айлчлал хийв.



Tolui Khaan

Айлчлалын үеэр талууд улс төр, аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, технологи, зам тээвэр, ложистик, соёл, аялал жуулчлал, иргэдийн солилцоо зэрэг хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх бодит арга хэмжээний талаар болон бүс нутаг, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солилцов. 2024 онд тохиох Монгол, Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 70 жилийн ойг тохиолдуулан хоёр улсын харилцааг “Иж бүрэн түншлэл”-ийн түвшинд хүргэх чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаар санал нэгджээ.



2023.11.02. Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгчийн ордон (Ханой хот)

Талууд 2019 онд байгуулсан “Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай санаамж бичиг”-ийн хэрэгжилтийг үр дүнтэйгээр хангаж үргэлжлүүлэн ажиллахаар тохирлоо. Монгол Улсаас БНСВУ-д экспортлох ямаа, хонины махны “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” болон БНСВУ-аас Монгол Улсад экспортлох шувууны мах, махан бүтээгдэхүүний “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ”-г тус тус харилцан тохирсон нь хоёр улсын хооронд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний солилцоо хийх таатай нөхцөл бүрдүүлэв.



Айлчлалын үеэр талууд дараах баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:



Дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр;



Монгол Улсаас БНСВУ-д экспортлох ямаа, хонины махны “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ” болон БНСВУ-аас Монгол Улсад экспортлох шувууны мах, махан бүтээгдэхүүний “Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ”.



Цагаан будааны худалдааны тогтвортой нийлүүлэлтийн тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Аж үйлдвэр, худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;



Үндэстэн дамнасан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тухай Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

Стратеги судалгааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;



Хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;

Мэдээлэл солилцоо болон цагаачлалын менежментийн тухай Монгол Улсын Хууль зүй, Дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг;



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх гэргийн хамт Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч Во Ван Тьонг болон Вьетнамын ард түмэнд Монголын төлөөлөгчдийг халуун дотно, найрсгаар хүлээн авч буйд талархал илэрхийлж, Ерөнхийлөгч Во Ван Тьонг-ийг ирэх 2024 онд тохиох Монгол, Вьетнамын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 70 жилийн ойн хүрээнд Монгол Улсад төрийн айлчлал хийхийг урив.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ГАДААД БОДЛОГЫН ЗӨВЛӨХ
Эрдэнэцогтын ОДБАЯР:




**Ерөнхийлөгчийн
санаачилсан
хөдөлгөөн дэлхий
нийтийн тулгамдсан
асуудлуудыг
шийдвэрлэхэд хувь
нэмэр оруулна**



Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх хөрс, хүнс, хүнээ эрүүл байлгахыг эрхэмлэн гурван салбарыг түлхүү дэмжиж байна. Энэ хүрээнд “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” гэсэн гурван хөдөлгөөнийг санаачлан эхлүүлсэн. Эдгээр хөдөлгөөн амжилттай хэрэгжих нь зөвхөн манай улсад бус олон улсын түвшинд ач холбогдолтой зүйл юм. Бид ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй үндэсний хөдөлгөөнүүдээр дамжуулан дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна гэсэн үг. Үүнийг гаднын улс орнууд болон олон улсын байгууллагууд эерэгээр харж, сайшааж байгаа. Мөн харилцан ашигтай хамтын ажиллагааг эхлүүлэх санамж бичиг, гэрээнүүдэд гарын үсэг зурсан нь манай улсын үндэсний үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдэд маш том боломж болж, дэлхийн зах зээлд гарах замыг нь нээж өгсөн. Үүнээс гадна айлчлалын

бүрэлдэхүүнд салбар тус бүрийн бизнес эрхлэгчдийг багтаан бизнес форум болон бизнес аялал арга хэмжээнүүдийг зохион байгуулж тухайн улсын бизнес эрхлэгчидтэй хамтран ажиллах, туршлага судлах нөхцөлөөр хангадаг шинэ жишиг тогтоосон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалуудын гол онцлог нь зөвхөн манай тал айлчлаад өндөрлөх бус харилцан айлчилдаг буюу хоёр урсгалтай болсон явдал юм. Талууд харилцан айлчлал хийснээр найрсаг харилцаа, хамтын ажиллагаа илүү батжиж, гадаад харилцаагаа хөгжүүлэх шинэ боломж бүрддэг. Ирэх 2024 онд өмнөх туршлагауудаа суурилан дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд Монгол Улсын оруулж ирсэн хувь нэмрийг улам өсгөх, үндэсний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд гадаад харилцааг өргөтгөн хөгжүүлж, түүний үр өгөөжийг улам нэмэгдүүлэхийг зоринo.



“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтэд 57 байгууллага хамтран ажиллаж байна

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор 2022 оны зургаадугаар сарын 17-ны өдөр “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол, 2023 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр “Монгол улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын түр хорооны 02 дугаар тогтоол батлагдсан.

Тогтоолыг хэрэгжүүлэхэд төрийн 40 гаруй байгууллага, арилжааны 10 банк, олон улсын байгууллагууд, хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэн судлаачид, холбоод гэсэн 50 гаруй байгууллага хамтран ажиллаж буй юм.

Дээрх байгууллагууд 6 сар тутамд нэг удаа хуралдаж үндэсний хөдөлгөөний үр дүн, хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл, санал солилцдог.


Тодруулбал, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг - I 2023 оны нэгдүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан. Уулзалтаар УИХ-ын 36 дугаар тогтоолыг эрчимжүүлэх, оролцогч талуудын төлөвлөлт, уялдаа холбоог хангах, санхүүжилтийн сахилга батыг сайжруулах талаар нээлттэй санал солилцов.

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг - II 2023 оны зургаадугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Хурлаар УИХ-ын 36 дугаар тогтоолын эхний жилийн /2022.06.17-2023.06.17 хүртэлх/ хэрэгжилтийн явц, 36-р тогтоолыг эрчимжүүлэх зорилго бүхий Улсын Их Хурлын түр хорооны 02 дугаар тогтоол, Засгийн газрын 63 дугаар тогтоолын төлөвлөлт,

хэрэгжилтийн явцын талаар холбогдох газрууд мэдээллээ танилцуулж байв.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний үр дүнд гол нэрийн 19 төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамж хэдэн хувиар өсөж, хэчнээн ам долларыг эх орондоо үлдээж чадсан эсэх, мөн ХАА-н салбарын баялаг бүтээгчдэд олгосон “Хөрөнгө оруулалтын зээл”-ээр хэчнээн бүтээн байгуулалт хийгдэж, техник, технологи нэвтэрч, “Эргэлтийн хөрөнгийн зээл”-ээр хэчнээн тоо, хэмжээний бүтээгдэхүүн шинээр болон нэмэлтээр үйлдвэрлэж, ажлын байр нэмэгдсэн эсэхийг бодитоор тайлагнаж, ажиллахыг холбогдох байгууллагуудад анхааруулж байв.

Хамтран хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын идэвх саарч, үр дүн багасах эрсдэлтэй гэж үзсэн тул ЕТГ-ын Даргын 108 дугаар захирамж гарч, УИХ-ын 36-р тогтоол болон түр хорооны тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх хоёр ажлын хэсэг байгуулагдсан.





УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг нарийвчлан тооцох урьдчилсан хэлэлцүүлгүүд боллоо

УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг нарийвчлан тооцож, хариуцагч байгууллага бүрийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг нэгтгэн 3 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгүүдэд үүрэг болгов.

Энэ хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хүнсний төсөл, хөтөлбөрийн албанаас УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг нарийвчлан тооцох зорилгоор 2024 оны 2 дугаар сарын 21-27-ны өдрүүдэд 7 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Урьдчилсан хэлэлцүүлгээр УИХ-ын 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг хариуцагч байгууллага тус бүрийн төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, тодруулга авав.



УИХ-ын 36 дугаар тогтоолын биелэлтэд онцгой анхаарч ажиллахыг анхааруулав

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэгч байгууллагуудын 3 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт 2024 оны гуравдугаар сарын 05-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдав.

Зөвлөлдөх уулзалтаар ЕТГ-ын даргын 108 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсгүүд 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, хариуцагч байгууллага бүрийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг нэгтгэн танилцуулж, цаашдын арга хэмжээний талаар хэлэлцэв.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар 3 дахь удаагийн зөвлөлдөх уулзалтад хэлсэн үгэндээ УИХ-ын 36-р тогтоолын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр нийт 18 арга хэмжээний биелэлт хангалтгүй буюу тогтоолд тусгасан шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулах нийт 10 хуулийн төслүүд нь батлагдаагүй байгаа бөгөөд салбар яамд онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг анхаарууллаа.

Түүнчлэн Монгол Улсын эдийн засгийн 15

хувийг дангаараа бүрдүүлж, жилдээ 7.2 их наяд төгрөгөөр хэмжигдэх баялаг бүтээж буй мал аж ахуйн үйлдвэрлэлд олгогдсон зээлийн хэмжээ нийт зээлийн ердөө 6.5 хувийг эзэлж байгаа талаар,

2024 оноос эхлэн малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөврийг НӨАТ-аас чөлөөлж байгаа талаар,

мөн УИХ-ын 36-р тогтоолд тусгагдаагүй боловч Худалдааны хуулийг боловсруулж батлуулах шаардлагатай зэрэг асуудлаар санал солилцов.

Хэлэлцүүлэгт Улсын Их хурлын Тамгын газар, УИХ-ын Байнгын хороод, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, холбогдох яамд, төрийн байгууллага, хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд, мэргэжлийн холбоод бүхий 57 байгууллагын 120 гаруй албаны хүмүүс оролцлоо.

Хэдий өндөр гүйцэтгэлтэй байгаа ч бодит байдал дээр хүртээмжгүй байна. Тухайлбал мал аж ахуйн салбарт чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байгаа тул 2024 онд тус салбарт ахиц дэвшил гаргах шаардлагатай.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар:

“Төрийн байгууллагууд хариуцсан ажлаа цаг тухай бүрт нь хэрэгжүүлж, “Хүнсний хувьсгал”-ыг бодит үр дүнд хүргэх хэрэгтэй.”



Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай:
Эрх зүйн орчноо сайжруулах, хүнсний аюулгүй байдлын хяналтад анхаарахгүй бол “Хүнсний хувьсгал”-ыг хойш нь татах эрсдэлтэй.



Төрийн банкны Тэргүүн дэд захирал Д.Сугар:
Зээл авч байгаа иргэн, аж ахуй нэгжүүд банкны шалгуур үзүүлэлтээс гадна газар тариалангийн талбайгаа хашаажуулах, бордсон байх гэх мэтчилэн тодорхой хэмжээнд өөрсдөөс шалтгаалах зүйлээ бэлдвэл зээл олголт нэмэгдэх боломжтой.



ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ:
Хөрөнний үржил шим болон үрийн шинэчлэлтэд анхаарах шаардлагатай байна.



Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лаборатори (ХАБҮЛЛ)-ийн захирал О.Нандин-Эрдэнэ:
ХАБҮЛЛ улсын хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангая гэвч тоног төхөөрөмж, хүний нөөцийн асуудлыг шийдэхгүй бол ямар ч боломжгүй.



Хүнсний салбарт идэвхтэй хэрэгжиж буй бодлогын гол хөшүүрэг “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн

Цар тахал ба геополитикийн ээдрээтэй нөхцөл байдлаас шалтгаалан дэлхий даяар хүнсний хангамж ноцтой доголдож буй энэ цаг үед улс орны хүнсний аюулгүй байдлыг хангах нь нэн тулгамдсан асуудал болж байна. Хүнсний хомсдолтой дэлхий ертөнц хүрэлцээгээ хангахын тулд цаашид элдэв генетик, химийн гаралтай хүнс үйлдвэрлэл дэлхийд ихсэх, хүн амын хүнс тэжээлийн дутагдлаа нөхөх гэсэн сөрөг үр дагавар болох баталгаагүй, гарал үүсэл тодорхойгүй бүтээгдэхүүнээс Монгол Улсаа хамгаалах хамгаалалт нь Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн үндэсний зорилт болгон эрчимжүүлж буй “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн юм.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний гол зорилго нь Монгол Улс ирэх таван жилд гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, цаашид хүнс экспортлогч орон болох, мөн малын өвчингүй эрүүл бүс бий болгох юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс хүнсний үйлдвэрийн салбарын нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, тулгамдсан асуудлуудыг шийдэх, гарц гаргалгааг хамтдаа тодорхойлох зорилгоор 200 орчим аж ахуйн нэгжид ажиллаад байна.

Төрийн тэргүүн улс төрийн манлайлал үзүүлэн үйлдвэрлэгчдийн санал хүсэлтийг сонсон, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа нь дотоодын үйлдвэрлэгчдэд томоохон дэмжлэг болж байна. Үндэсний үйлдвэрлэгчид “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг цаг үеэ хамгийн зөв мэдэрсэн, төр, засгийн зүгээс шаардлагатай бодлого шийдвэрүүдийг гаргасан бодит ажил хэрэг болж байгаад талархалтай хандаж байлаа.



**Үндэсний үйлдвэрлэгчид
2025 он гэхэд дотоодын өндөгний
хэрэгцээг бүрэн хангана**

“НВЦ” ХХК-ийн “Баян” өндөгний үйлдвэр нэг сая толгой шувуутай. Өдөрт 600 мянган өндөг дотоодын зах зээлд нийлүүлдэг бөгөөд дэгдээхэй бойжуулах, өндөг ангилан савлах, хагас боловсруулсан бүтээгдэхүүний болон тэжээлийн үйлдвэр зэргийг цогцоор нь байгуулжээ. 2023 онд улсын хэмжээнд 500 орчим сая өндөг зах зээлд борлуулагдсаны 300 сая буюу 60 орчим хувийг дотоодын аж ахуйн нэгжүүд нийлүүлсэн байдаг. Тэгвэл үүний 50 гаруй хувийг “НВЦ” ХХК-ийн “Баян” өндөгний үйлдвэр дангаараа хангажээ. Мөн тэд дэлхийн өндөг үйлдвэрлэлийн хамгийн сүүлийн үеийн технологийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлсэн анхдагч юм.

Монгол Улсын хүн амын өндөгний хэрэглээ жилээс жилд нэмэгдэж байна. Тухайлбал бид 2021 онд 330 сая ширхэг өндөг хэрэглэж байсан бол 2022 онд 430 сая ширхэг, 2023 онд 500 орчим сая ширхэг болж нэмэгджээ. Тэгвэл өсөн нэмэгдэж буй дотоодын өндөгний хэрэглээг үндэсний үйлдвэрлэгчид 2025 он гэхэд 100 хувь бүрэн хангах боломжтой гэж байна.

**“НВЦ” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Ц.Баатарбилэг:**



Бид өнгөрсөн 20 жилийн хугацаанд алхам алхмаар хөгжсөөр өнөөдрийн байдлаар 1 сая толгой шувуутай болсноор монголын хамгийн том шувууны аж ахуй болжээ. 2024 ондоо бид шувууныхаа тоо толгойг 1.5 саяд хүргэх зорилго тавиад байна. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Хүнсний хувьсгал”-ын хүрээнд энэ олон үйлдвэрлэгч нарын санаа бодлыг сонсож, бидэнтэй уулзан зөвлөмж, бодлого, чиглэл гаргаад явж байгаад туйлын их баяртай байна.



Манай улсын өндөгний хэрэглээ жил бүр нэмэгдсээр байгаа ч нэг хүн жилд дунджаар 120 ширхэг өндөг хэрэглэдэг гэсэн судалгаа байгаа. Энэ нь дэлхийн дунджаас 2-3 дахин бага үзүүлэлт юм.



Өндөгний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд тэжээлийн технологи хариуцсан болон тэжээлийн үйлдвэрийн автомат, электрон тоног төхөөрөмжийн мэргэжилтэн дутагдаж байгааг хэллээ. Мөн Монголд ургадаггүй үр тариаг гааль болон НӨАТ-ыг өндөг үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг нь жигдэртэл чөлөөлөх хүртэл дэмжлэг үзүүлэхийг хүсэв.



5 жилийн дотор импортын бэлэн гоймонг 40-50 хувиар бууруулна



“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний зорилгод нийцсэн үндэсний үйлдвэрлэгчдийн нэг бол “Хүнс сервис” ХХК юм.

Тус компани “Алтан тариа”, “Улаанбаатар гурил”, “Өег” зэрэг дотоодын үйлдвэрлэгчдээс түүхий эдээ авч, зориулалтын агуулахдаа нөөцлөн, иргэдэд хямд, чанартай, баталгаатай, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнгүй, хадгалалтын хугацаа уртасгагч бодисгүй гурил үйлдвэрлэж байна.

Өдөрт 6-7 тонн гурилаар 14 төрлийн жигнэж хэрчсэн бэлэн гурил үйлдвэрлэж, бүтээгдэхүүнээ сургууль, цэцэрлэг, нийтийн хоолны газрууд болон сүлжээ дэлгүүрүүдэд нийлүүлдэг ажээ.

“Хүнс сервис” ХХК-ийн хувьд үйлдвэрлэлээ өргөжүүлж 4300 мКв шинэ байраа ашиглалтад оруулжээ. Цаашид тус компани хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадвал үйлдвэрийн тоног төхөөрөмжөө бүрэн автоматжуулж, 2 ээлжээр өдөрт 20 тонн бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай болж өргөжих аж. Тэд гурван үйлдвэрийн төсөл төлөвлөсөн байгаа бөгөөд

төслийн дагуу 70-100 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болно гэв.

Цаашид тус компани болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 100 гаруй аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалтын зээлд аль болох хамруулж байвал таван жилийн дотор дотоодын зах зээлээ бүрэн хангаж, улмаар экспортод гаргах боломжтой гэж үздэгээ илэрхийллээ.

“Хүнс сервис” ХХК-ийн ерөнхий захирал Ш.Саранчимэг:



“Хүнсний хувьсгал” бол монголчууд эрцл хүнсээ үйлдвэрлэн, өөрсдөө эрцлжих боломж гэж талархаж байна.



Үндэсний үйлдвэрлэлийн тулгын чулуу болсон хөнгөн аж үйлдвэр

*Монгол Улсын
Ерөнхийлөгч
Ухнаагийн Хүрэлсүх
“Хүнсний хангамж,
аюулгүй байдал”
үндэсний хөдөлгөөний
хүрээнд хөнгөн
үйлдвэрийн салбарт
үйл ажиллагаа
явуулж буй аж
ахуй нэгжүүдэд
ажиллалаа.*



“Цагаан алт” Үндэсний хөдөлгөөн



Монгол анхны оймсны үйлдвэрлэгч “Янмал” ХХК малчдын гар дээрээс түүхий ноос авч, угаах, самнах, ээрэх, будах дамжлагын үйлдвэрүүддээ эцсийн бүтээгдэхүүн болгон дотооддоо төдийгүй гаднын 20 орчим улсад экспортолж байна. Өдөрт 20 мянган хос цэвэр даавуун, ноосон оймс, эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд дотоодын оймсны зах зээлийн 60 орчим хувийг хангадаг байна.

Цар тахлын жилүүдэд тухайн үеийн Засгийн газар аж ахуйн нэгжүүдийн дулаан, цахилгаан, ус зэргийн төлбөрийг төрөөс даах шийдвэр гаргасан нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, ажлын байраа хадгалж үлдэхэд томоохон дэмжлэг болсныг “Янмал” ХХК-ийн үүсгэн байгуулагч Д.Лхагважав хэллээ.

“Янмал” ХХК-ийн менежер Л.Дуламханд:

“ Малчны хотноос ноос авахаас эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх бүх шат дамжлага маань 100 хувь үндэсний үйлдвэрлэл.”



Түүхий ноосыг эцсийн бүтээгдэхүүн болгон экспортолж байна

Монгол Улс 30 гаруй сая хоньтой, жилдээ 36 мянган тн ноос ашигладаг. Цаашид хөнгөн үйлдвэрийн салбараа хөгжүүлж, түүний дотор ноос бэлтгэх, нийлүүлэх, боловсруулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах тогтолцоо бүрдүүлэх ёстой гэж Ерөнхийлөгч үздэг.

Тэрээр малын гаралтай түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байр бий болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, малчдын орлогыг нэмэгдүүлж, ахуй амьдралыг нь сайжруулах зэрэг нөхцөл бүрдүүлэх зорилгоор “Цагаан алт” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхээ мэдэгдээд буй юм.

Энэ хүрээнд Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хөнгөн аж үйлдвэрийн салбарынхан болон арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг баялаг бүтээгчидтэй уулзан, тулгамдаж байгаа асуудал, гарц, шийдлийг эрэлхийлж санал солилцлоо.





Ноолуураа самнаж экспортлоод 600 сая ам.доллар олох боломжтой

“Ханбогд Кашимер” ХХК нь 500 гаруй ажилтантай бөгөөд 80 гаруй хувь нь эмэгтэйчүүд юм байна. Жилд 1,500 гаруй тонн ноолуур боловсруулж, 200,000 ширхэг сүлжмэл, 150,000 ширхэг нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тус компанийн хувьд өнгөрсөн 25 жилийн хугацаанд ноолуурын экспортоор тэргүүлэгч аж ахуйн нэгжийн нэг болж, валютын нөөцийг нэмэгдүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулж иржээ. Цаашид манай улс ноолуураа самнаж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснээр 4,000 ажлын байр бий болж, 600 сая ам.долларын орлого олох боломж байгаа тухай гүйцэтгэх захирал Ч.Ганцэцэг уулзалтын үеэр хэлж байв.



Ноолуурыг орлох монгол хонины нарийн ноос



Үндэсний үйлдвэрлэгч “Могол Ноос” ХХК нь “Могол” брэндийн ноосон даавуу, драп, пальто, пиджак, нэхмэл шааль, ороолт зэрэг оёмол болон сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үйлдвэрээ өргөтгөн хүчин чадлаа гурав дахин нэмснээр жилд 5,000 тн ноос, ноолуур угаах боломжтой болсон бөгөөд бүтээгдэхүүнийхээ 80 хувийг экспортод гаргадаг. Үүний зэрэгцээ самнах болон ээрмэл утас, оёдлын үйлдвэрлэл эрхэлж байна. Тус компани Монголдоо анх удаа хонины ноосноос ноолууран ширхгийг ялган авч нарийн утас үйлдвэрлэж байгаагаараа онцлогтой.

Монгол хонины ноосноос ноолуурыг ялгаж, 100% ноосон болон 10%, 30% ноолуурын холиотой ээрмэл утас үйлдвэрлэж, ээрсэн утсаараа ноосон болон ноолуурын холиотой даавууг монголдоо кластераар хамтран үйлдвэрлэн “Могол” брэндийн пальто үйлдвэрлэсэн нь Монгол Улсад анх удаа ноосон болон ноолуурын хольцтой үндэсний пальтоны брэндийг бий болгов.

Манай улс жилд импортоор 450-500 тн ээрмэл утас авдаг бөгөөд “Могол” үйлдвэр нэхмэл, сүлжмэлийн 300 тн бүдүүн ээрмэл утас үйлдвэрлэдэг. Хүчин чадлаа бүрэн ашиглавал дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломж байна. Дотоодын үйлдвэрүүдийн нарийн ээрмэл утасны хэрэгцээ жилд 25 тн байдаг. “Могол ноос” ХХК-ийн хүчин чадал жилийн 150 тн юм байна.





Ноос түүний давуу тал



Монгол хонины ноос нь монгол орны тэсгим хүйтний улиралд дасан зохицсон ноолуурлаг ширхэгт ихтэй байдаг онцлогтой. Монголчууд эрт дээр үеэс хонины нэхий, ноосон бүтээгдэхүүнийг амьдрал ахуйдаа хэрэглэдэг байсан нь ноос түүний эрүүл ахуйн ач холбогдлыг мэддэг байсантай холбоотой. Эрдэмтэд ноос нь хүний эрүүл ахуйн ач холбогдлыг судлан тогтоосон хэсгээс сонирхуулахад.

1. Ноос халуунд сэрүүн, хүйтэнд дулаан байдаг.

2. Ноос галд тэсвэртэй.

3. Дуу чимээ тусгаарладаг.

4. Цахилгаанждаггүй.

5. Ус чийг шингээж дулаан ялгаруулдаг нь хүйтэнд хүний биеэс ялгарсан чийгийг шингээж дулаан ялгаруулдаг.

6. Ноос хүний арьснаас цахилгаан цэнэгийг шингээж, үр дүнд биеийн өвчтэй хэсэг дулаацаж цусны эргэлт сайжруулж өвдөлт намдааж, хаван буулгадаг.

7. Ноосон өлгий, нэхийнд хүүхэд түргэн тайвширч, уйлах нь бага байдаг. Сайн унтах нь хүүхдэд жин хурдан нэмэх өсөлт хурдан байхад нөлөөлдөг. Мөн нэхий, ноосны үснээс гарах энерги нь эхийн энергитэй төстэй байдаг учир нэхийнд өлгийдсөн хүүхэд тайвширч гүн нойрсох хандлагатай байдаг гэж эрдэмтэд нотолсон байна.

8. Ноосон хөнжил, гудас нь хүн унтаж байх явцад биеэс ялгарах чийг дулааны солилцоог нэмэгдүүлж ая тухтай нойрсох нөхцөл бүрдүүлдэг.

9. Ноос биеийн дулааныг барьдаг учир цусан хангамжийг сайжруулах судас нарийсахаас сэргийлдэг.


10. Эдэлгээ сайтай зэрэг хүний биед ээлтэй олон шинж чанартай, өдөр тутам амьдрал ахуйд хэрэглэдэг байгалийн гаралтай ширхэгт юм. Ийм ч учраас онгоцны нисгэгч, үйлчлэгчдийн хувцсанд хамгийн тохиромжтой материалаар сонгогдог байна.

16 жилийн турш кластераар ажиллаж иржээ

2008 ноос хойш үйл ажиллагаагаа явуулж буй “Блю Скай Кашемир” үйлдвэр технологийн иж бүрэн цогц үйлдвэр нь ямааны ноолуур, хонины ноос, сарлагийн хөөвөр, тэмээний ноосыг боловсруулан утас болгож, хөнжил, даавуу, драп, плед, алчуур, шааль, ороолт, малгай, өмд, цамц, пальто зэрэг 1000 гаруй нэр төрлийн нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна.

Жилд 250 тн ноос, ноолуур будах, 60 тн ээрмэл утас, 500 мянган уртааш метр нэхмэл бүтээгдэхүүн, 70 мянган ширхэг сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай, Итали, Герман, Япон, Англи улсуудын сүүлийн үеийн дэвшилтэт машин тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон, 100 гаруй ажлын байрыг бий болгоод байна.

Нийт бүтээгдэхүүнийхээ 80 хувийг 10 гаруй улсад экспортолдог бөгөөд ноолуураас гадна сарлагийн хөөвөр, тэмээний ноос, хонины ноосон бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд нийлүүлдэг. Цаашид үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлж, дотоод болон гадаад зах зээл дэх байр сууриа тэлэхийг зорьж байна.



Монголын цагаан алт гэгдэх хонины ноосоор бусад ижил төстэй үйлдвэрүүдтэй кластераар хамтран ажиллаж, хонины бүдүүн ноосны ноолуурлаг хэсгээр үйлдвэрлэсэн ээрмэл утсаар Монголд анх удаа даавуу үйлдвэрлэж, эцсийн гүйцэтгэн боловсруулалт хийх инновацийг нэвтрүүлэн бүрэн нутагшуулжээ.

Ийнхүү малын гаралтай ноос, ноолуураар төрөл бүрийн даавуу драп, нарийн даавууг олон улсын ижил төрлийн бүтээгдэхүүний жишигт нийцүүлэн үйлдвэрлэж боловсруулдаг болсон нь оёдлын салбар хөгжих, байгалийн гаралтай натурал, экологийн цэвэр түүхий эд материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний брэндийг бий болгоход Монгол Улсад стратегийн ач холбогдол бүхий шийдэл болжээ.





Сарлагийн хөөврийг боловсруулж, үнэ цэнийг нь 10 дахин өсгөжээ

“Бодиос” брэндээрээ олны танил болсон “Баялаг-Өлзий” ХХК 2005 оноос торомны ноос, сарлагийн хөөврөн утас үйлдвэрлэж дотоодын сүлжмэлийн үйлдвэрүүдэд нийлүүлж эхэлсэн түүхтэй. Торомны ноосыг том тэмээний ноосноос тусад нь ялгаж боловсруулдаг технологийг эх орондоо анх нутагшуулсан байна. Өдгөө 150 гаруй ажилтантай, жилд 100 мянган бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сүлжмэлийн үйлдвэр, 410 тн бохир ноолуур угаах, 60 тн самнасан цагаан ноолуур үйлдвэрлэх хүчин чадалтай анхан шатны боловсруулах үйлдвэртэй, түүхий эд бэлтгэлийн бааз суурь бүхий 700 өрхийг хамарсан хоршоотой болжээ.



“Цагаан ямаат кашемир” үйлдвэр зөвхөн цагаан ноолуур боловсруулдаг, олон улсын ноолуурын мөрдөн мөшгөх системийн тогтолцоо хэрэгжүүлсэн байна. Өмнө нь огт ашигладаггүй, байгалийн жамаараа гуужиж хаягддаг байсан сарлагийн хөөврийг самнаж бэлтгэх аргыг малчидтай хамтран боловсруулж, хөөврийг нь худалдаж авдаг болсноор үнэ цэнийг нь 10 дахин өсгөж чаджээ.





Дэлхийд цор ганц технологи ба хонины хаягдал ноосон бордоо

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт байрлах “Монпеллетс” ХХК-ийн био бордооны үйлдвэр нь жилд 2,500 тн бордоо үйлдвэрлэх хүчин чадалтай, одоогоор жилд 125 тн-ыг үйлдвэрлэж ХБНГУ, АНУ-д экспортолж байна. Цаашид хүчин чадлаа бүрэн ашиглаж, бүтээгдэхүүнээ Япон, БНСУ-д нийлүүлэх, бусад улс оронтой хамтран ажиллахаар төлөвлөжээ.

Үйлдвэрлэлийн технологи нь зөвхөн угаагаагүй хонины ноос хэрэглэдэг бөгөөд химийн болон нэмэлт туслах бодис, ус ашигладаггүй дэлхийд цор ганц технологи юм.



Монгол Улсын бордооны жилийн хэрэглээ 150 мянган тн бөгөөд цаашид жилд 10 хувиар өсөх төлөвтэй байна. Манай улс жилд 170 сая ам. доллароор химийн бордоо гаднаас худалдаж авдаг.

Био бордоо нь усыг өөртөө шингээн хадгалдаг бөгөөд шаардлагатай үед буцаж ялгаруулдаг, 10-14 сарын хугацаанд задарч, байгальд шингэдэг. Газрын хөрсийг сийрэгжүүлэн хөвсийлгөж, хорхой шавжаас хамгаалдаг, ургамлыг дээд зэргийн тэжээл болон усаар хангадаг юм байна.

Манай улсын хөрсний чанар муудаж, ялзмагийн агууламж 60, ургамал шинжтэй тэжээлийн бодис 60-80 буурсан нь хүнсний ногоо тарих, арвин ургац авахад сөргөөр нөлөөлдөг. Ийм үед био бордоог жимс, жимсгэнэ, мод, бут, сөөг, тасалгааны болон мандлын цэцэг, хөрс, задгай талбай, хүлэмжийн ногоо, уул уурхайн биологийн нөхөн сэргээлтэд ашиглахад үр дүнтэй нь дотоод, гадаадын улс орнуудын туршилтаар батлагджээ.

“Монпеллетс” ХХК-ийн Үүсгэн байгуулагч Б.Цогбадрах:



“Манай улс жилд 170 сая ам. доллароор химийн бордоо гаднаас худалдаж авдаг юм. Учир нь хүнсний ногоо тариалагч жижиг, дунд аж ахуйн нэгжүүд био бордоог худалдан авах чадвар бага. Иймээс төрийн бодлогоор дэмжих, ялангуяа кластерийн системд оруулан зохицуулалт хийвэл богино хугацаанд иргэдээ эрцл ногоогоор хангах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулах, импортын бордоог орлох бүрэн боломжтой.

**“Хүнсний хангамж, аюулгүй байдал”,
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний адил
арьс, ширний үйлдвэрлэлийн салбарыг
бүх талаар далайцтай дэмжихийг хүсэв**

Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн
холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан:

**“Хүнсний хангамж, аюулгүй
байдал”, “Тэрбум мод” үндэсний
хөдөлгөөний адил арьс, ширний
үйлдвэрлэлийн салбарыг бүх талаар
далайцтай дэмжих, Нийгмийн
даатгалын шимтгэлийг эргэж харах
шаардлагатай, ингэвэл кластер
хэлбэрээр хөгжих бүрэн боломжтой.**

**Олон улсын “LWG” стандарт
нь арьс ширний үйлдвэрийн
салбарт үйл ажиллагаа эрхэлж
буй байгууллагын явцыг
байгаль орчин, химийн бодисын
менежмент, ханган нийлүүлэлт,
зохистой хэрэглээ, эрүүл мэнд,
болон аюулгүй ажиллагаа,
нийгмийн хариуцлага зэрэг
асуудлуудтай холбоотойгоор
үнэлэх зорилго бүхий байгаль
орчны олон улсын аудит юм.**

90 жилийн түүхт “Булигаар” ХК нь үхэр болон
ямааны арьсанд эцсийн боловсруулалт хийн
төрөл бүрийн гутлын дээд биений болон дотрын
материалыг дотоодын зах зээлд нийлүүлдэг.
Түүнчлэн хагас боловсруулсан вет-блю болон краст
түвшинд экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Дэлхий нийтээрээ хэрэглэгчдийн чиг хандлага
эко үзэл баримтлал руу чиглэж байгаа тул дэлхийн
томоохон брэнд хувцас, гутал үйлдвэрлэгчид зөвхөн
“LWG” стандартын гэрчилгээтэй арьсаар бүтээгдэхүүн
үйлдвэрлэх болсон. Эдгээрээс дурдвал бид бүхний
мэдэх дэлхий нийтэд танигдсан Adidas, ALDO, Colum-
bia, ECCO, GANT, GEOX, HUGO, BOSS, IKEA, Prada, Puma,
Salamander, Timberland Tommy Hilfiger, Tory Branch,
Under Armour зэрэг үйлдвэрлэгчид бий.

2024.01.11 Монголын
анхны арьс ширний
үйлдвэр “Булигаар” ХК



“Мон-Ирээдүй” ХХК нь арьс, шир зэрэг түүхий
эдийг хагас боловсруулан олон улсын зах зээлд
гаргахын зэрэгцээ бог малын арьсаар зөөлөн
савхи, гутлын дотор эдлэлийн зориулалттай
савхи, бодын ширээр гутлын дээд бие, цүнхний
зориулалттай арьс, шир үйлдвэрлэж байна. Тус
компанийн хувьд 2020 онд салбартаа анхлан
Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо
ISO 9001 стандартыг хэрэгжүүлж, арьс ширний
салбарын хөгжлийг шат ахиулжээ.



Монголын анхны хувийн гутлын үйлдвэр
“Хос аз” ХХК /2024.01.11/

Гутал үйлдвэрлэгчдэд төрийн худалдан авалт хамгийн том дэмжлэг

Монголын анхны хувийн гутлын үйлдвэр “Хос аз” ХХК жилд нэг ээлжиндээ 100 мянган хос гутал үйлдвэрлэх хүчин чадалтай. Өдөрт 300 хос гутал зах зээлд нийлүүлдэг. Нийт гутлын 80 хувийг



Батлан хамгаалах яам, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг хүчний байгууллагуудын офицер, албан хаагчдын гутал, хөдөлмөр хамгааллын, тусгай зориулалтын гутал эзэлж байна. Үүнээс гадна эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн болон тусгай хэрэгцээний бүх төрлийн гутал үйлдвэрлэж байна.


Монголчууд хүүхдийн хөлийг дулаан байлгах чийгтэхгүй байлгах тал дээр ихээхэн анхаардаг. Тэгвэл “Хос аз” компани нь Монгол, Италийн цэвэр арьс шир, нэхий болон гутлын үйлдвэрлэлд шинээр хэрэглэгдэж байгаа хөвөн даавуун, гал усанд тэсвэртэй материал ашиглан Европ Стандартын Монгол хүүхдийн гуталны коллекц гаргажээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч У. Хүрэлсүх МАНУХолбооны гишүүн, Марис ХХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа.

MARIS брэнд нь үнэ цэнэ шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотооддоо нийлүүлэхийн зэрэгцээ Дэлхийн зах зээлд гаргахыг зорин ажиллаж байна.

“Хос аз” ХХК-ийн Ерөнхий захирал, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан Н.Зоригт:



Цар тахлын жилүүдэд тухайн үеийн Засгийн газар аж ахуйн нэгжүүдийн дулаан, цахилгаан, ус зэргийн төлбөрийг төрөөс даах шийдвэр гаргасан нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, ажлын байраа хадгалах, улмаар цалингаа нэмэх боломж олгосонд талархдаг.



Монгол Улс жил бүр 6 сая орчим гутал импортоор оруулж ирж худалдаалдаг. Манай улсын дотоодын гутлын үйлдвэрүүд ердөө 5 хувь хүрэхгүй хувийг л ханган ажилладаг. Үндсэндээ 40 гаруй тэрбум төгрөгийг зөвхөн гадны гутал үйлдвэрлэгчдийг дэмжихэд зарцуулдаг байна.



Гутал үйлдвэрлэлийн салбартаа тэргүүлэгч “Бэст шүес” компани 2024 оноос гутлын түрийнд гадуур улыг шууд цутгадаг автомат машиныг эх орондоо анх нэвтрүүлжээ. Эдүгээ 100 гаруй ажилтантай, суурилагдсан хүчин чадал нь өдөрт 600 гаруй хос гутал үйлдвэрлэх боломжтой ч зах зээлийн эрэлтээс шалтгаалан хагас хүчин чадлаар ажилладаг аж. “Дотоодын гутлын үйлдвэрүүдээ төрийн худалдан авалтаар дэмжих нь хамгийн том дэмжлэг болно” гэдгийг уг салбарын баялаг бүтээгчид хэлж байв.



**“Бэст шүес”
ХХК-ийн захирал
Б.Түвдэнням:**



“Бид гаднын улсууд шиг дотоодын бүтээгдэхүүнийхээ чанар, хэрэглээг ухамсарласан, үнэнч хэрэглэдэг байдлаас суралцах хэрэгтэй. Хэдий өндөр зэрэглэлийн арьс, ширээр гутал үйлдвэрлэсээр байхад чанар муутай импортын гутлыг илүү үнээр авдаг. Чанаргүй гутал хурдан муудаж, удалгүй дахин худалдан авах шаардлага үүсдэг. Харин сайн арьсан гутлыг зөв арчлаад он удаан өмсдөг. Үүнийг дотоодод үйлдвэрлэдгийг хүчхдийн бага наснаас ухамсарлуулж, эх оронч хэрэглэгчдийг бэлтгэх хэрэгтэй байна. Нийтийн нүдэнд харагддаггүй болохоос манай улсын гутал үйлдвэрлэлийн чанар, түүхий эд, технологийг, үйлдвэрлэгч орнууд сонирхож, туршилага судалдаг.



Монголын арьс, ширний үйлдвэрлэлийн холбооны гүйцэтгэх захирал Т.Баярсайхан:



“Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний адил арьс, ширний үйлдвэрлэлийн салбарыг бүх талаар далайцтай дэмжих, Нийгмийн даатгалын шимтгэлийг эргэж харах шаардлагатай. Ингэвэл кластер хэлбэрээр хөгжих бүрэн боломжтой.





Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Үйлдвэр, үйлчилгээний бодлогын зөвлөх
Ч.Даваабаяр:



**Хүнсний хувьсгал, Цагаан
алт, Шинэ хоршоо үндэсний
хөдөлгөөнүүд нь цогцоороо
хэрэгжиж, Хөдөө аж
ахуйн салбарт томоохон
ХУВЬСГАЛ хийнэ.**

“Хүнсний хувьсгал” хөдөлгөөнийг ганц салбарын яам хэрэгжүүлэх бололцоогүй. Үндэсний хэмжээний хөдөлгөөн гэдэг утгаар нь авч үзвэл олон талын оролцоо чухал байна байх?

- Монгол Улсын Ерөнхийлөгч улс орны нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор “Халамжаас хөдөлмөрт, Олборлолтоос боловсруулалтад, Импортоос экспортод” шилжих суурь реформын хүрээнд “100 жил-10 зорилт” хөгжлийн санаачилгыг дэвшүүлсэн. Энэхүү санаачилгын нэг чухал зорилт нь хүнсний аюулгүй байдлыг хангах, эрүүл, аюулгүй хүнсээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлэх, бүс нутагтаа хүнс экспортлогч улс болох явдал юм.

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт 114 ажлыг төлөвлөн ажиллаж байна. Үндсэн ажлыг нугалах салбар бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам юм. Түүнчлэн уг хөдөлгөөнийг хэрэгжүүлэхээр УИХ-ын дөрвөн байнгын хороо, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэдэх Хүнсний төсөл хөтөлбөрийн алба, Хүнс, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтдийн зөвлөл, төрийн захиргааны 35 байгууллага, олон улсын байгууллагууд, “Хүнсний хувьсгал” ТББ,

арилжааны 10 банк, хэвлэл мэдээллийн баг зэрэг өргөн бүрэлдэхүүнээр ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг экспортлох асуудлыг та юу гэж бодож байна вэ?

- Монгол Улс бол мал аж ахуйн орон. Энэ утгаараа эдийн засгийн томоохон хөшүүрэг болно гэдэгт итгэдэг. Мал аж ахуйн салбарт 240 гаруй мянган айл өрх, 60 гаруй сая мал маллаж ахуй амьдралаа залгуулан, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд тодорхой хувь нэмэр оруулан ажиллаж байна. Хэдий хангалттай тооны малтай, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, дотоодын хэрэгцээгээ хангах, цаашлаад экспортлох бүрэн нөөц боломж байгаа мэт харагдаж байгаа боловч малын эрүүл мэндийн асуудлыг бодлогоор шийдвэрлэхгүй бол хүн амын хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, экспортын зах зээлд байр сууриа эзлэхэд хүндрэл учирна. Иймд Монгол Улсын Засгийн газраас экспортыг дэмжих зорилгоор тусгаарлах бүс байгуулах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2022 онд 27 тэрбум төгрөг, 2023 онд 59,4 тэрбум төгрөг, 2024 онд 69.8 тэрбум төгрөг тус тус төсөвлөн ажиллаж байна.

Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдал,



экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг тогтвортой ажиллуулахын тулд **WOAH** (Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага) **CODEX** (Хүнсний аюулгүй байдлын конвенц) гэсэн суурь стандартыг нэвтрүүлэх шаардлагатай.

Бид дээрх стандартыг нэвтрүүлснээр нэгдсэн нэг чанарт шилжиж, монгол махны брэндийг бий болгож, нэг цонхны бодлогоор махыг экспортолно.

Мөн адил манай газар тариалангийн салбар сэргэн хөгжиж, сүүлийн жилүүдэд хангалттай хэмжээний ургацыг хүлээн авч, улаанбуудай, улаанбуудайн гаралтай бүтээгдэхүүн (хивэг, гурил, хүүхдийн будаа) төмс болон зарим төрлийн тэжээлийг экспортлох боломж харагдаж байна.

Иймд Дэлхийн худалдааны байгууллагын “Эрүүл ахуй, ургамлын хорио цээрийн арга хэмжээг хэрэгжүүлэх хэлэлцээр”, ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох Ургамал хамгааллын олон улсын конвенц (**IPCC**)-д нэгдэх шаардлагатай байна.

Ер нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 77 хувь нь цөлжилтөд өртөөд байна. Малчид тооны араас биш мах, сүүний чиглэлийн гэх мэт ашиг шимээр төрөлжүүлэх, газар тариалангийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон технологийг нэвтрүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах нь чухал.

Манай улс жимс жимсгэнийг бараг 100 хувь гаднаас оруулж ирдэг. Тус хөтөлбөрт энэ талаар ямар зорилт дэвшүүлээд байна вэ?

- Монгол Улсын Ерөнхийлөгч Хүнс эрүүл бол монгол хүн эрүүл байна. Монгол хүн эрүүл бол монгол үндэстэн хүчирхэг байна гэдгийг УИХ-ын чуулганы индэр дээрээс хэлсэн. Жимс жимсгэнэ бол хүн амыг эрдэс, амин дэмээр хангах, хүнсний шим тэжээлийг нэмэгдүүлэх үнэт түүхий эд. Ийм ч утгаараа бид ургадаг хүнсийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан, тарих модны 200 сая нь жимс, жимсгэнийн мод байхаар зорилтыг дэвшүүлсэн.

Хяналтын тогтолцоог хэрхэн сайжруулах вэ?

- Хүнсний аюулгүй байдлын хяналтын тогтолцоог сайжруулах нь бидний тулгамдсан асуудлын нэг. Тэр дундаа хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдааны аюулгүй байдалд нэн тэргүүнд анхаарах нь зүйтэй. Ийм ч утгаараа хүнсний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангасан төвлөрсөн худалдааны төв, логистикийн төвтэй болох хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл, жижиглэнгээр худалдан борлуулах эрхээ тухайн худалдааны төвөөс авдаг тогтолцоонд бид шилжих хэрэгтэй. Бүтээгдэхүүний хадгалалт, хүргэлтийг нэг дор төвлөрүүлсэн төвөөр дамжуулж хүнсээ шийддэг туршлага олон улсад байна. Хүнсний түүхий эд бүтээгдэхүүний худалдаа ийм жишиг тогтолцоо руу шилжих нь энэхүү хөдөлгөөний нэг хэсэг байх болно.

Ингэснээр хүнсний түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл илүү тодорхой, аюулгүй байдал хангагдахын зэрэгцээ хяналт тавихад хялбар болно.

Үндэсний хөдөлгөөний зорилтот хугацаанд бид ямар үр дүнд хүрсэн байх бол?

“Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнсний үйлдвэрүүд болон сав, баглаа боодлын зэрэг хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллаж буй иргэд, ААН-үүдэд чиглэсэн гааль, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, бага хүүтэй, урт хугацаатай санхүүжилт олгох зэрэг олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар нийт нэг их наяд гаруй төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна. Үр дүнд нь баялаг бүтээгч үндэсний үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа өргөжин тэлж, зохих амжилтад хүрэхийн зэрэгцээ хэд хэдэн экспортын үйлдвэрүүд шинээр бий болсон.

УИХ-ын 36-р тогтоолыг бүрэн төгс, бодитоор хэрэгжүүлж чадвал монголчууд бид 19 гол нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, цаашлаад 56 нэрийн бүтээгдэхүүнийг дотоодоосоо



хангах болно. Цаашлаад дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортын нэр төрөл нэмэгдэнэ гэж харж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд тохиолдсон цар тахал, дайн тулаан, тээвэр логистикийн хүндрэл, ажилгүйдэл, ядуурал, өлсгөлөн, бараа бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт зэрэг нь улс орон бүрийг аж үйлдвэрийн салбартаа онцгой анхаарах шаардлагатайг харуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчийн Тамгын газрын зүгээс аж үйлдвэрийн салбар луу чиглэсэн ямар арга хэмжээ авч байна вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч хөнгөн үйлдвэрийн салбарыг шинэ шатанд гаргах, тэр дундаа өсөн үрждэг баялаг болох мал аж ахуйн салбарт малын гаралтай түүхий эдийг үнэ цэнд оруулах, үйлдвэрлэл болон экспортыг нэмэгдүүлэх, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог сайжруулах чиглэлд бодит үр дүн гаргах шаардлагатай хэмээн үзэж “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг санаачлан улс орон даяар өрнүүлэхээр төлөвлөөд байна.

Ерөнхийлөгчийн санаачилсан бодлого, үйл ажиллагааны хүрээнд “Цагаан алт” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон санхүүжилтийн талаар санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Манай улсын хөнгөн аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа бөгөөд 41 мянган ажлын байрыг тогтвортой байлгаж байна.

Гэвч “Хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын дөнгөж 6 хувьтай тэнцэж байна. Өөр нэг тоо баримт нь манай улс жил бүр гаднаас гутал, хувцас, арьс, савхин эдлэл зэрэг хөнгөн үйлдвэрийн шинжтэй бараа бүтээгдэхүүн авахад 3 тэрбум ам.доллар зарцуулж байна. Гадагш урсгаж буй энэ мөнгийг

бид дотооддоо үлдээх шаардлагатай. Бидэнд хангалттай боломж бий.

Учир нь үндэсний үйлдвэрлэгчид өөр хоорондоо кластерийн системээр хамтран ажиллаж малын мах, сүү, арьс шир, ноос ноолуур зэрэг таван хошуу малынхаа амьсгалаас бусдыг нь эцсийн бүтээгдэхүүн болгон үнэ цэнд хүргэж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлснээр ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах зэрэг улс орны хөгжил дэвшилтэй холбоотой нийгэм, эдийн засгийн олон төрлийн үр өгөөж, ашиг шим ирнэ.

Малчид хоршоо болон нэгдэж 50 хүртэлх сая төгрөгийн зээл авах боломж бүрдэх үү?

“Шинэ хоршоо” хөдөлгөөн нь ган зудад тэсвэртэй чинээлэг малчидтай, анхан болон дунд шатны хоршоодоор дамжин хагас эрчимжсэн мал аж ахуйн салбарыг бий болгож үндэсний үйлдвэрүүдэд тогтмол нийлүүлэх зорилготой юм. Уг хөдөлгөөн амжилттай хэрэгжсэнээр мал аж ахуйн салбараас гадна, хүнс болоод хөнгөн үйлдвэрийн салбарт ч мөн ахиц гарах юм.

Тус хөтөлбөр хэрэгжсэнээр малчид сайн дураараа хоршоо болон нэгдэж, хоршоонд элссэн малчид арилжааны банкнаас 3-5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэй хөрөнгө оруулалтын чиглэлийн 50 сая төгрөгийн зээлийг Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан 80-100% батлан даалган зээл авах боломжтой.

Хүнсний хувьсгал, Цагаан алт, Шинэ хоршоо үндэсний хөдөлгөөнүүд нь цогцоороо хэрэгжиж Хөдөө аж ахуйн салбар томоохон ХУВЬСГАЛ хийнэ.

Ярилцсан: Б.Туул
Монголы үндэсний мэдээллийн
МОНЦАМЭ агентлаг



Ус, сүүг урвалд оруулахгүй, хүнс муутгахгүй эко савыг дотооддоо үйлдвэрлэж эхэллээ

Хүнсний зориулалтын бус хуванцар савны найрлагад ордог химийн бодисууд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шингэн, улмаар хүний биед орж хуримтлагдсаар олон төрлийн өвчний суурь шалтгаан болдог. “Эко усны сав” ХХК БНСУ-аас өндөр нягтралтай полиэтилен HDPE буюу олон улсын чанарын гэрчилгээтэй түүхий эд ашиглан усны сав үйлдвэрлэж байна.



Сав баглаа боодлын салбар жилд 150 орчим тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна

Сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгч “ОБ Пластик” ХХК нь 170 орчим ажилтан, 70 орчим машин, тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дотоодын гялгар уут, баглаа боодлын зах зээлийн 50-60 хувийг дангаараа хангадаг байна.



“Монлабел” компани нь үндэсний үйлдвэрлэгчдийн, ялангуяа бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг олон төрлийн материал дээр үйлдвэрлэж дотоодын хүнс үйлдвэрлэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна.

Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг багасгах нь “Хүнсний хувьсгал”-ын бас нэг зорилт

Үндэсний үйлдвэрлэгч “Чиглэл” ХХК ундны усны 60-250 литрийн багтаамжтай суурин болон зөөврийн ган сав үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна. Дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн стандартын шаардлага хангасан нийтийн хоолны тоног төхөөрөмж, сав баглаа боодлыг хэрэглэж хэвших нь гаднаас орж ирж буй зориулалтын бус хуванцар савны хэрэглээнээс үүсэх өвчин эмгэг, хорт хавдар зэргээс сэргийлэх ач холбогдолтой.



Монголын анхны цаасан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр “ЭкоПак Монгол” ХХК

“ЭкоПак Монгол” ХХК-ийн цаас дахин боловсруулах үйлдвэр нь нийлүүлэгчдээс хаягдал цаас худалдан авч, 100 хувь саарал ус ашиглан хайрцаг, сав, баглаа боодлын анхдагч түүхий эд болох бор цаасыг үйлдвэрлэж байна. Хоногт 30 тонн бор цаас үйлдвэрлэх хүчин чадалтай тус үйлдвэр жилд дунджаар 25.2 сая ширхэг цаасан хайрцаг үйлдвэрлэх боломжтой юм. Энэ нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг импортоор авч буй зардлыг дотооддоо үлдээх боломжийг бүрдүүлж байна.



“Шинэ Гантиг” ХХК нь 2016 оноос Монгол Улсын хөнгөн үйлдвэрийн салбарт уул уурхайн хүнд даацын шуудай үйлдвэрлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус компани нь уул уурхайн хүнд даацын шуудайны зах зээлийн ууган үйлдвэрлэгчдийн нэг бөгөөд уг салбарт байгуулагдсан 2 дах үндэсний үйлдвэрлэгч юм.

Цар тахлын жилүүдэд тухайн үеийн Засгийн газар дулаан, цахилгаан, ус зэргийн төлбөрийг төрөөс даах шийдвэр гаргасан нь үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, ажлын байраа хадгалахад томоохон дэмжлэг болсонд компанийн удирдлагууд талархал илэрхийллээ.

Цаашид “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний адил хөнгөн аж үйлдвэрийн салбарыг бүх талаар далайцтай дэмжих, урт хугацаатай хүү багатай зээл олгож, татварын бодлого болон төрийн худалдан авалт зэргээр дэмжвэл хөнгөн үйлдвэр кластер хэлбэрээр хөгжиж дотоодын хэрэгцээг хангаж, экспортоо нэмэгдүүлэх боломжтойг уг салбарт баялаг бүтээж буй үндэсний үйлдвэрлэгчид хэлж байлаа.

Мөн иргэн бүр үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, эх оронч хэрэглэгч байх нь “Үйлдвэрлэгч, баялаг бүтээгч, экспортлогч орон” болж, эдийн засгийн тусгаар тогтнолоо бататган бэхжүүлэх гол тулгуур гэдгийг хэлэв.

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2023 оны байдлаар хөнгөн үйлдвэрийн салбар нийт аж үйлдвэрийн салбарын 25 хувийг дангаараа бүрдүүлж байна. Ноос, ноолуур, арьс шир, мод, модон тавилга, оёмол бүтээгдэхүүн, хувцас, хэвлэл, сав, баглаа боодол, дахин боловсруулах, гоо сайхан, ахуйн химийн чиглэлээр 3,200 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэрт 44 орчим мянган хүн ажиллаж байгаа юм.

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспорт 2022 оны жилийн эцсийн байдлаар 508 сая ам. доллар, импорт 703 сая ам. доллар болсон статистик үзүүлэлт гарчээ. Экспортын дийлэнх хувийг нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн тэр

дундаа ноолуур эзэлдэг бол модон эдлэл, хэвлэл, цаас, картонон бүтээгдэхүүний экспорт маш бага хувьтай байна.

Гэвч “Хөнгөн үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний экспорт манай улсын нийт экспортын дөнгөж 6 хувьтай тэнцдэг бөгөөд хүнс, гутал, хувцас, арьс, савхин эдлэлээс эхлээд хөнгөн үйлдвэрийн шинжтэй бараа бүтээгдэхүүн гаднын улс орнуудаас худалдан авахад жилд ойролцоогоор 3 тэрбум орчим ам.долларыг гадагш урсгаж байна.

Хөнгөн үйлдвэрийн салбарт төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Хөнгөн үйлдвэрийн салбарт төр, засгаас шат дараалсан дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал өнгөрсөн онд 20 гаруй мянган малчинд зургаан тэрбум гаруй төгрөгийн ноосны урамшуулал олгосон. Энэ онд урамшуулалд 23 тэрбум гаруй төгрөг зарцуулах юм байна.

Өнгөрсөн онд мөн 38 аж ахуйн нэгжид 170 тэрбум төгрөгийг хөнгөлөлттэй зээл, 18 тэрбум төгрөгийг хүүгийн татаас хэлбэрээр олгожээ.

“Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Арьс, шир бэлтгэл, үйлдвэрийн зээл авсан аж ахуйн нэгжүүд 2022 онд 14 тэрбум гаруй төгрөгөөр түүхий эд, туслах материал худалдан авч, 1.2 тэрбум гаруй төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэн, хоёр тэрбум гаруй төгрөгийн татвар төлсөн байна.

Хүнс, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах зориулалттай, тухайн үйлдвэрийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх шинэ тоног төхөөрөмжийг импортын барааны гаалийн албан татвараас 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл 100 хувь хөнгөлсөн. Энэ хөнгөлөлтөд хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын 426 нэр төрлийн тоног төхөөрөмж хамрагдаж байна.



Монгол Улсын эдийн засгийн тулах цэг бол мал аж ахуй юм

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГЫН ЗӨВЛӨХ
Батсуурийн
ДАВААДАЛАЙ

Хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг уламжлалт мал аж ахуйн салбар, тэр дундаа нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйг шинжлэх ухаанчаар зөв хослуулах, малын ашиг шимийг бүрэн гүйцэд ашиглах, малчдын орлого, амьжиргааг сайжруулах явдал нь “Хүнсний хувьсгал”-ын амин чухал нэгэн зорилт юм.

Тиймээс малчдын залгамж халааг бэлтгэх, малын эрүүл мэндийг хамгаалах, нэгдэж хоршиж ажиллах, малын үүлдэр угсааг сайжруулах, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах зэрэг олон асуудлуудад “Хүнсний хувьсгал” онцгой анхаарч байна.

Ирэх 2024 онд малын вакцинжуулалт, био-бэлдмэлийн үйлдвэрлэлд онцгой анхаарч, Монгол Улс малын өвчингүй эрүүл бүс болоход түлхүү анхаарна. Цаашлаад цөлжилт, шороон шуурганы эрсдэлийг бууруулах, ногоон хөгжлийг дэмжих, хүнс, хөдөө аж ахуйн кластер, цогцолборуудыг байгуулах, түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын нэгдсэн тогтолцоо, тээвэр логистикийн оновчтой сүлжээг бий болгох, жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, шинэ техник технологийг нэвтрүүлэхэд онцгой анхаарах болно.

Үндэсний үйлдвэрлэгчдэд



**“Мон Ирээдүй” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Л.Биндэрьяа:**

*Бид дахин давтагдашгүй
монгол малын арьс ширийг
дэлхийн стандартад*

*нийцүүлэн боловсруулж, өндөр хөгжилтэй
орнуудад экспортолж байна.*



**“Бест шүес” ХХК-ийн
Үйлдвэрийн дарга Б.Эрдэнэ:**

*Гутлын цутгамал улны
үйлдвэрлэлийг бид Монголд
анхдагч болон оруулж ирсэн.*

**“Мон Ирээдүй” ХХК-ийн
Үйлдвэрийн дарга
С.Нарантуяа:** Манай
үйлдвэрийн хувьд гутал,
хувцасны зориулалттай
арьсыг Герман технологиор
боловсруулж байна.



**“Усны Эко сав” ХХК-ийн
захирал Х.Пүрэвсүрэн:**

*Бид ард иргэдийг эрүүл
аюулгүй усны саваар хангах
зорилгоор савыг саваар солих
ажил өрнүүлнэ.*

**“Баялаг Өлзий” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Г.Ундрах:**
*Сарлагийн хөөврөн
бүтээгдэхүүнийг илүү
тансаг зэрэглэлд хургээж,
дэлхийн зах зээлд гаргах нь
бидний зорилго.*



**“Блю Скай Кашимер” ХХК-ийн
Будах үйлдвэрийн дарга
Д.Мөнхтуяа:** Манай үйлдвэр
ноос, ноолуурыг Европ
стандартын 100-120
төрлийн өнгө будгаар будаж байна.



**“Ханбогд Кашимер” ХХК-ийн
Ерөнхий захирал, Монгол
Улсын Хөдөлмөрийн баатар
Ч.Ганцэцэг:** Ерөнхийлөгч
аж үйлдвэрийн салбарыг
дэмжсэн бодлого гаргаж
байгаад баяртай байна.



**“Блю Скай Кашимер” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Б.Эрдэнэбаяр:** Ноос,
ноолуурын салбарынхан
олон улсын зах зээлд “Монгол
гэх баялаг”-ийг бүтээж
байна.



**“Мон Лабел” ХХК-ийн
Ерөнхий захирал
Н.Батмөнх:** Ерөнхийлөгч
манай үйлдвэрийн үйл
ажиллагаатай танилцсанд
баяртай байна.

ТӨРИЙН ДЭМЖЛЭГ ХАМГИЙН ЧУХАЛ



“Могол Ноос” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэбат: “Цагаан алт” хөдөлгөөн бүрэн хэрэгжвэл Монгол Улсын иргэн бүр хонины ноосоо өмсөх, үйлдвэрчүүд бүтээгдэхүүнээ экспортлох, ажлын байр олноор бий болох боломжтой болно.

“Монпеллетс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Б.Алтангадас: Малчдаас угаагаагүй ноос авч өндөр технологиор боловсруулан хөрсний хамгийн сайн чанартай бордоог үйлдвэрлэж байна.



“ОБ Пластик” ХХК-ийн Захирал Ж.Отгонбаяр: Хууль бусаар импортлож байгаа нимгэн тор дотоодын үйлдвэрлэгчдэд сөргөөр нөлөөлж байна.



“Чиглэл” ХХК-ийн Ерөнхий захирал Ц.Бумцэнд: Эрцүл хүнс үйлдвэрлэхэд эрцүл сав баглаа, боодлоор хангах нь чухал.

“Булигаар” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхболд: Монголын арьс ширний үйлдвэрчүүд хөгжлийнхөө шинэ шатанд гараад явж байна. Арьсаар бүтээгдэхүүн хийдэг ЖДҮҮ эрхлэгчид, үйлдвэрчүүдийн чадавх сайжирсан.



“Ханбогд Кашимер” ХХК-ийн Ерөнхий инженер Н.Эрдэнэболд: “Ханбогд Кашимер” нь бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг учраас улсынхаа эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг.

“Шинэ Гантиг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Цэрэннадмид: Манай үйлдвэрийн хувьд анхдагч түчүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгч. Биднийг дотоодын худалдан авалтаар дэмжээд өгвөл бид дотоодын зах зээлийн 60-70 хувийг дангаараа хангах бүрэн боломжтой.



“ЭкоПак Монгол” ХХК-ийн Захирал Ч.Мөнхбаяр:

Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөн нь үндэсний үйлдвэрлэгчдээ дэмжих, гадагшаа урсах мөнгөн урсгалыг багасгах, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох зэрэг эдийн засгийн олон талын ач холбогдол, үр ашгийг үзүүлэх томоохон санаачилга.



“Тод Оймс” ХХК-ийн Захирал Б.Баяржаргал: “Хүнсний хувьсгал” шиг хөтөлбөрөөр хөнгөн үйлдвэрийг дэмжвэл олон үйлдвэр хөл дээрээ босно.

“Өлзий хаалга” ХХК-ийн Захирал Б.Ариунболд: Эх орондоо импортын хаалганаас илүү хямд, чанартай хаалга үйлдвэрлэж байна.



“Альфа Филтер” ХХК-ийн Захирал И.Мөнхбат: Бид 3 жилийн дотор дотоодын зах зээлийн 30 орчим хувийг хангах боломжтой.



“Янмал” ХХК-ийн Ерөнхий захирал Д.Лхагважав: Монгол иргэдийнхээ эх оронч худалдан авалтаар бид өнөөгийн түвшинд хүрсэн.



ХҮНСНИЙ ХАНГАМЖ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ

№04
2024 ОН

2024.05.01

СЭТГҮҮЛ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үйлдвэр,
үйлчилгээний бодлогын зөвлөх,
доктор (Ph.D), профессор

Чимиддоржийн ДАВААБАЯР:

“ХҮНСНИЙ ХУВЬСГАЛ,
ЦАГААН АЛТ, ШИНЭ ХОРШОО
үндэсний хөдөлгөөнүүд нь цогцоороо
хэрэгжиж, Хөдөө аж ахуйн салбарт
томоохон ХУВЬСГАЛ хийнэ



WWW.HUNSNIIHUVISGAL.MN

Дугаарыг эрхлэн гаргасан:
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР